



Mongol Bank



МОНГОЛБАНК

ИНФЛЯЦЫН ТАЙЛАН

2020

12-Р САР

АГУУЛГА

Мөнгөний бодлогын стратеги.....	3
Мөнгөний бодлогын шийдвэр	4
I. ИНФЛЯЦ	7
Инфляцын динамик	7
Инфляцын цаашдын төлөв.....	8
II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	9
Эдийн засгийн цаашдын төлөв.....	12
III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН.....	14
III.1. Хөдөлмөрийн зах зээл	14
III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл	16
III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд	16
III.2.2 Хүү	19
III.2.3 Валютын хани	19
III.2.4 Хөрөнгийн зах зээл	21
III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	23
IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН.....	24
IV.1 Гадаад эдийн засгийн орчны талаарх төсөөлөлд ашигласан таамаглал.....	24
IV.2 Түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ.....	28
IV.3 Төлбөрийн тэнцэл.....	29

**МОНГОЛБАНК**

ИНФЛЯЦЫН ТАЙЛАН

2020 оны 12-р сар

Мөнгөний бодлогын стратеги

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй урт хугацаанд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанкны **2020 оны инфляцын зорилтот түвшин 8 хувь**, харин 2021 оноос дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулах юм.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшинг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсхүл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдахад чиглэсэн арга хэмжээг бодлогын хүүтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк зах зээлийн итгэлийг олж, хүлээлтийг удирдах замаар мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй нээлттэй харилцахад ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ ба зардлын хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтийн хүртээл болгож байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, мөнгөний бодлогын шийдвэр гаргагчдын зорилтыг олон нийтэд ийнхүү нээлттэй танилцуулснаар Монголбанкны бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанкинд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Мөнгөний бодлогын шийдвэр (2020 оны 4-р улирал)

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо КОВИД-19 цар тахал дотоодод тархаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ээлжит бусаар хуралдлаа. Энэхүү хуралдаанаар:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
2. Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд тогтоох;
3. Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргалаа.

Мөнгөний бодлогын 2020 оны 11-р сарын 23-ны мэдэгдлийг [эндээс](#) уншина уу.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны төлөв байдал, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг хэвээр хадгалах;
2. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 1-р улиралд 250 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргалаа.

Мөнгөний бодлогын 2020 оны 12-р сарын 18-ны мэдэгдлийг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр татаж авна уу.

ТОЙМ

Төсөв, мөнгөний бодлогын багц арга хэмжээнүүд нь хэрэглээ, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжиж байгаа хэдий ч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил огцом суларч эдийн засаг энэ онд агшихаар байна. Нийлүүлэлтийн доголдол үүсэхгүй тохиолдолд инфляц нам түвшинд хадгалагдах хандлага хэвээр байна.

Инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө ирэх саруудад нэмэгдэхээргүй байна. 2020 оны 10 дугаар сард инфляц улсын хэмжээнд 2.4 хувь, Улаанбаатар хотод 2.6 хувьд хүрч сүүлийн саруудад тогтвортой байлаа. 11-р сард дотоодод КОВИД-19 вирус тархсантай холбоотойгоор махны үнэ улирлын хандлагаасаа эрт өссөн хэдий ч Засгийн газрын шийдвэрээр сайжруулсан түлшний үнийг 75 хувь бууруулж, нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэхээргүй байна. Харин КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эрэлт буурч, эрэлтийн шалтгаантай инфляц бага байхаар байна. Цаашид нийлүүлэлтийн шалтгаантай үнийн огцом хэлбэлзэл үүсэхгүй гэж үзвэл инфляц 2020 оныг дуустал нам түвшинд хадгалагдаж, 2021 оноос алгуур нэмэгдэн Төв банкны зорилтот түвшин (6%)-ий орчимд тогворжих хүлээлттэй.

КОВИД-19 цар тахал дотоодод тархаж, нөхцөл байдал богино хугацаанд өөрчлөгдсөнөөр эдийн засаг 2020 онд огцом агшиж, 2021 онд алгуур сэргэх төлөвтэй байна. Энэ оны 3-р улиралд эдийн засаг сэргэх хандлага ажиглагдсан ч өсөлт хүлээлтээс доогуур гүйцэтгэлтэй гарав. Үүнд цар тахлын сөрөг нөлөө болон төсвийн хөрөнгө оруулалтын зардал дутуу гүйцэтгэлтэй байснаас шалтгаалан барилга, боловсруулах, худалдаа, тээвэр, уул уурхайн салбарын үйлдвэрлэл төсөөлөлд хүрч нэмэгдээгүй нь нөлөөлөв. Түүнчлэн, 11-р сард вирусын халдвар дотоодод тархаж бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласан нь уул уурхай, хөдөө аж ахуй, мэдээлэл холбооны салбараас бусад салбаруудад сөргөөр нөлөөлж, улмаар энэ оны 4-р улиралд эдийн засгийн идэвхжил эргэн суларлаа. Ирэх онд гадаад эрэлт сэргэж, хөрөнгө оруулалт нэмэгдэж, уул уурхайн үйлдвэрлэл эрчимжих хэдий ч хөл хорионы дэглэм, цар тахлын тархалтын улмаас дотоод эдийн засгийн сэргэх хугацаа удааширч байна. Эдийн засгийн цаашдын төлөв хэрхэн өөрчлөгдөх нь дотоодод тархсан КОВИД-19 вирусыг хяналтдаа оруулах хугацаанаас хамаарч байна.

Төсвийн зарцуулалттай холбоотойгоор мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт энэ оны 2-р хагасаас алгуур нэмэгдэх хандлагатай байна. М2 мөнгөний жилийн өсөлт энэ оны 10-р сард 10.1 хувь болж нэмэгдэхэд Засгийн газрын бараа, үйлчилгээний зардал, иргэдэд олгох нийгмийн халамжийн шилжүүлэг болон төсвийн хөрөнгө оруулалтын зардал хэлбэрээр аж ахуйн нэгжүүдэд олгох санхүүжилтүүд нь голлон нөлөөлсөн байна. Харин КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор дотоод эдийн засгийн идэвхжил сул байгаагийн дээр зах зээлийн эрсдэл нэмэгдсэн нь зээлийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Гадаад орчинд эерэг өөрчлөлт ажиглагдаж байгаа ч тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Pfizer, Moderna зэрэг вакцины эхний туршилтууд 90-с дээш хувийн үр дүнтэй байгаа тухай мэдээ гадаад орчинд эерэг дохиог өгч байна. Мөн БНХАУ, АНУ, Евро бүс, Орос зэрэг томоохон эдийн засагтай орнуудын 2020 оны 3-р улирлын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарав. Хэдийгээр цар тахлын шинэ давалгаанууд үүсч эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч тархалтыг хяналтад оруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж нэмэгдэхийн зэрэгцээ эдийн засгийн сэргэлтийн хүлээлт харьцангуй өөдрөг хэвээр байна. Цаашид “КОВИД-19” вирусын эсрэг үр дүнтэй вакцин хэзээ хэрэглэгддэг бэлэн болох,

түүний хүрэлцээ болон үйлдвэрлэлийн чадамжаас гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байна.

Төлбөрийн тэнцэл 2020 онд ашигтай гарах төлөвтэй байна. Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны 3 дугаар улиралд 207 сая ам.доллар буюу ДНБ¹-ий 1.6 хувьтай тэнцэх ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 398.4 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болов. Үүнд экспорт сэргэж, импорт хумигдан, орлогын дансны алдагдал буурснаар урсгал тэнцэл 148.7 сая ам.долларын ашигтай гарсан нь голлон нөлөөлөв. Энэ оны 11-р сард дотоодод вирус тархсан нь улс хоорондын ачаа тээврийг хязгаарлаж, улмаар экспорт удаашрах эрсдэлийг үүсгэж байгаа нь төлбөрийн тэнцэлд тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

Гадаад худалдааны нөхцөл энэ оны 10-р сард өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар сайжирлаа. Тодруулбал, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар нэмэгдсэн бол импортын үнэ 10.8 хувиар буурчээ. Төсөөллөөр алтны үнэ буурсан боловч зэс, төмрийн хүдрийн үнийн төсөөлөл нэмэгдэж, худалдааны нөхцөл 2020 оны 4-р улиралд сайжрахаар байна.

¹ 4-н улирлын өссөн нэмэгдсэн ДНБ-ий дүн.

I. ИНФЛЯЦ


Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулах зорилттой ажиллаж байна.

Инфляцын динамик

Тайлант улиралд эдийн засгийн идэвхжил аажим сэргэх хандлагатай байж **эрэлтийн гаралтай** үнийн өсөлт харьцангуй тогтворжсон бол **нийлүүлэлтийн шалтгаантай** үнийн хөдөлгөөн буурах чиглэлд давамгайлсан тул инфляц үргэлжлэн саарч III улиралд дунджаар 2.1 хувь байв (Зураг I.2). Хүнсний инфляц нэмэгдэж буй мөн өмнөх оны суурь нөлөөгөөр инфляц IV улиралд нэмэгдэж 11 дүгээр сард улсын хэмжээнд жилийн 3.5 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 4.3 хувьд хүрэв (Зураг I.1).

Зураг I.1

Инфляц



Эх сурвалж: УСХ

Тайлант улиралд цар тахлын нөлөөгөөр хөрөнгө оруулалт хумигдан, зах зээлд оролцогчдын хүлээлтэд тодорхой бус байдал сөргөөр нөлөөлж, зээлийн өсөлт сааран үнэ өсөх эрэлтийн дарамт бага хэвээр байв. Дотоодод халдвар хамгааллын дэглэмийг шат дараатайгаар зөөллөснөөр эдийн засгийн үйл ажиллагаа аажим сэргэх хандлагатай байсны зэрэгцээ мөнгөний бодлого, сангийн бодлого, макро зохистой бодлого зохицуулалтууд хэрэглээг тэтгэх нөлөөтэй байсан тул эрэлтийн шалтгаантай инфляц харьцангуй тогтворжих хандлагатай болов.

Инфляцыг нийлүүлэлтийн шалтгаантай өсгөж байсан хүчин зүйлсийн үнийн өсөлт энэ онд тогтворжиж, шатахууны үнэ инфляц буурахад нөлөөллөө (Зураг I.2, Зураг I.3).

Зураг I.2

Ерөнхий инфляц болон нийлүүлэлтийн шинжтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт




Эх сурвалж: УСХ, Монголбанк

- **Шатахууны үнэ** инфляцыг -1.0 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлсэн байна (Зураг I.3).
- **Махны үнэ** улирлын онцлогоосоо зөрж өсөн 11 дүгээр сард инфляцын 0.8 нэгж хувийг бүрдүүллээ. Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн эхний өдрүүдэд иргэдийн хүнс нөөцлөх эрэлт их байснаас ийнхүү үнийн инфляцад үзүүлэх нөлөө нэмэгдлээ (Зураг I.2, Зураг I.3).
- **Махнаас бусад хүнсний үнэ** өсч инфляцыг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэв. Тухайлбал, хүнсний ногооны үнийн инфляцад үзүүлэх нөлөө суурь нөлөөгөөр нэмэгдсэн бол сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ өмнөх жилээс харьцангуй өндөр өсч инфляцад үзүүлэх нөлөө нь нэмэгдлээ (Зураг I.3).
- Дотоодод КОВИД-19 цар тахлын халдвар тархсантай учраас 11 дүгээр сарын 11-ээс бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн. Энэ нь хатуу түлш, эм тариа эмнэлгийн бараа, үйлчилгээнээс бусад хүнсний бус бараа, үйлчилгээнд хязгаарлалт үүсгэв. Үүнээс үүдэн эрэлтийн гаралтай инфляц өмнөх сарын орчимд байв (Зураг I.2, Зураг I.3).

Зураг I.3

Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Төсөөллийн зөрүү

Гуравдугаар улирлын дундаж инфляц 2.1 байсан нь төсөөллөөс 0.3 нэгж хувиар доогуур байв.

Хүснэгт I.1 Инфляцын төлөвт гарсан өөрчлөлт

Инфляцын богино хугацааны төсөөллийн таамаглал	
Өмнөх төсөөлөл 2020Q3-2021Q2	Одоогийн төсөөлөл 2020Q4-2021Q3
Махны үнэ	Төсөөлөл нэмэгдсэн
Махны дундаж үнэ 7-р сард улирлын хандлагаасаа эсрэгээр өмнөх сараас өндөр байснаар үнийн төсөөлөл нэмэгдэв.	Махны үнэ III улиралд төсөөллөөс давж хямдарсан хэдий ч 11-р сараас үнэ нь өсч байгаагаас төсөөллийг нэмэгдүүлэв.
Импортын барааны үнэ	Төсөөлөл буурсан
II улирал, 7-р сард импортын барааны үнэ төсөөллөөс багаар өссөн.	Импортын барааны үнийн төсөөлөл III улиралд нийцтэй байсан бол төгрөгийн ханш тогтвортой байж, хөл хориотой холбоотой худалдан авалтын хязгаарлалт үүсч байгаагаас цаашдын төсөөллийг буурууллаа.
Дотоодын барааны үнэ	Төсөөлөл буурсан
Дотоодын барааны үнийн өсөлт 7-р сард төсөөллөөс бага байж төсөөлөл өмнөх улирлаас бага зэрэг саарлаа.	Дотоодын барааны үнийн төсөөлөл III улиралд нийцтэй байсан бол дотоодод халдвар гарсантай холбоотой Засгийн газраас авч буй арга хэмжээнд сайжруулсан түлшний үнийг 75%-аар хямдруулсан худалдаалах шийдвэр гарсныг төсөөлөлд тусгалаа.
Төрийн зохицуулалттай үнэ	Төсөөлөл хэвэндээ
Төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.	Төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.
Шатахууны үнэ	Төсөөлөл буурсан
Шатахууны үнэ 7, 8-р сард бага зэрэг өссөн хэдий ч, II улиралд төсөөллөөс давж буурсан.	Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой, гадаад зах зээл дэх газрын тосны үнийн төсөөлөл бага зэрэг саарсанаар төсөөллийг буурууллаа.

Эх сурвалж: Монголбанк


Махны үнэ төсөөллөөс давж хямдарснаар хүнсний бүлгийн үнийн өсөлт 2020 оны III улиралд жилийн 3.7 хувиар буюу төсөөллөөс багаар өслөө. Түүнчлэн хүнсний бус бүлгийн үнийн өсөлт, тэр дундаа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 2.8 хувиар өссөн нь төсөөллөөс бага байв.

Инфляцын цаашдын төлөв

Дотоодод тархсан КОВИД-19 цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн ч Засгийн газар сайжруулсан түлшний үнийг 75 хувь бууруулснаар инфляцын төсөөлөл энэ оны эцэст өмнөх төсөөллийн орчимд байх төлөвтэй (Зураг I.4).

Зураг I.4

Инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Хөл хорионы дэглэмтэй холбоотойгоор эдийн засгийн идэвхжил суларсны дээр нийлүүлэлтийн шалтгаантай үнийн огцом хэлбэлзэл үүсэхээргүй байгаа тул инфляц ирэх саруудад бага түвшинд хадгалагдахаар байна. Тодруулбал, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц хэвийн түвшинд байгаагийн² дээр хөл хорионы үед нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээг холбогдох байгууллагууд авч хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн төсөөлөл тогтвортой байгаа тул дотоодын шатахууны үнэ огцом өөрчлөгдөхөөргүй байна.

Хүснэгт I.2

Инфляцын төсөөлөл

	2019 гүйц.	2020* төсөөлөл	2021*
Инфляц, ХҮИ ³	6.1	3.2	6.3
Итгэх интервал ⁴		[2.8-3.7]	[4.7-8.0]

Эх сурвалж: Монголбанк

Ирэх оноос эдийн засгийн идэвхжил алгуур сэргэх хандлагыг даган инфляц аажим өсч,

² Эх сурвалж: ХХААХҮЯ³ Он тус бүрийн 4 дүгээр улирлын дундаж инфляц⁴ 30 хувийн магадлалтай итгэх интервал

Төв банкны зорилтот түвшний орчимд тогтворжих хүлээлттэй байна.

*Инфляцын төсөөллийг өөрчилж
болзошгүй тодорхой бус байдал*

- Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол эсвэл илүүдэл үүсвэл төсөөллийг өөрчлөх эрсдэлтэй. Тухайлбал, цаг агаарын нөхцөл, хөл хорионоос шалтгаалан мах, хүнсний ногооны бүтээгдэхүүний үнэ огцом хэлбэлзэх, төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ төсөөллөөс давж нэмэгдэх зэрэг нь инфляцын төсөөллийг өөрчлөх шалтгаан болно.
- КОВИД-19 цар тахлын дотоод дахь тархалт цаашид нэмэгдэж, улмаар хорио цээрийн арга хэмжээг чангатгах, хугацааг сунгах тохиолдолд эдийн засгийн идэвхжил үргэлжлэн суларч, инфляцыг бууруулах нөлөөтэй. Нөгөө талаас хөл хорионы дэглэм удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд хүнсний зарим бүтээгдэхүүний нөөцийн хомсдол үүсч, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт бий болж болзошгүй.
- Олон улсад геополитикийн эрсдэл нэмэгдэж, цар тахлын тархалт эрчимжиж гадаад орчинд тодорхой бус байдал өсвөл дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, улмаар төгрөгийн ханшид ирэх дарамт нь инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

- КОВИД-19 цар тахлын дотоод дахь тархалт цаашид нэмэгдэж, улмаар хорио цээрийн арга хэмжээг чангатгах, хугацааг сунгах тохиолдолд эдийн засгийн идэвхжил үргэлжлэн суларч, инфляцыг бууруулах нөлөөтэй. Нөгөө талаас хөл хорионы дэглэм удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд хүнсний зарим бүтээгдэхүүний нөөцийн хомсдол үүсч, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт бий болж болзошгүй.


- Олон улсад геополитикийн эрсдэл нэмэгдэж, цар тахлын тархалт эрчимжиж гадаад орчинд тодорхой бус байдал өсвөл дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, улмаар төгрөгийн ханшид ирэх дарамт нь инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Бодит ДНБ 2020 оны 3-р улирлын урьдчилсан гүйцэтгэлээр -3.1 хувиар, оны эхний 3 улиралд -7.3 хувиар агшлаа. Эрэлт талаас тайлант улиралд өрхийн болон Засгийн газрын хэрэглээ эдийн засгийн идэвхжлийг үргэлжлэн дэмжсэн бол хөрөнгө оруулалт нь өсөлтийг сааруулах нөлөөтэй байв. Экспорт, тэр дундаа түүхий эдийн экспорт тайлант улирлын олборлолтын хэмжээнээс давсан дүнтэй байсан бол импорт 3 дахь улиралдаа дараалан саарлаа (Зураг II.1).

Зураг II.1

Хөрөнгийн хуримтлал, экспортын орлого буурч,
нийт эрэлт агших голлох нөлөөг үзүүлэв⁵




Эх сурвалж: YCX

“Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлсэн, цар тахлаас сэргийлэх арга хэмжээг зөөлрүүлсэн зэргээс шалтгаалж тайлант улиралд эдийн засгийн идэвхжил сэргэх хандлага бий болсон хэдий ч уул уурхайн болон уул уурхайн бус салбаруудад агшилт үргэлжлэв. Дотоодын эдийн засгийн идэвхжил, импорт саарснаас шалтгаалж бүтээгдэхүүний цэвэр татварын бодит орлого буурав (Зураг II.2).

Зураг II.2

КОВИД-19-өөс сэргийлэх арга хэмжээ эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсээр байна.



Эх сурвалж: YCX


Хэрэглээ

Өрхийн хэрэглээ 3-р улиралд өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар тэлж, нийт эрэлтийг 4.0 нэгж хувиар дэмжлээ. Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлсэн цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх бодлого болон зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан арга хэмжээ хэрэглээг дэмжих нөлөөг үзүүллээ.

⁵ Сүүлийн 4 улирлын нийлбэрээс тооцсон өсөлт

Зураг II.3

Өрхийн хэрэглээний өсөлт сэргэж эхлэв



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Засгийн газрын хэрэглээ

Төрийн албан хаагчдын цалин, урамшууллын нэмэгдэлтэй холбоотойгоор төсвийн бараа, үйлчилгээний зардал тайлант улиралд бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар тэлж, нийт эрэлтийг 2.2 нэгж хувиар дэмжлээ.

Хөрөнгө оруулалт

Гуравдугаар улирлын дунд үеэс хөл хорио суларсан ч хөрөнгө оруулалт, тэр дундаа, барилга, машин төхөөрөмжийн хуримтлал удаанаар сэргэж байна.

Зураг II.4

Нийт хөрөнгийн хуримтлал буурав.



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Хэдийгээр бизнесийн зориулалттай зээл өсөлттэй, төсвийн хөрөнгө оруулалтын зардал өмнөх оны түвшинд хадгалагдсан ч ГШХО-ын орох урсгал, тэр дундаа Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалттай холбогдох зардал өмнөх оны мөн үеэс бага хэвээр байгаа нь аж ахуй нэгжүүдийн хөрөнгө оруулалт саарах шалтгаан боллоо.

Цэвэр экспорт

Цэвэр экспорт нийт эрэлтийг 14.8 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөөтэй байв. Тайлант улиралд экспорт бодит дүнгээр 8.8 хувиар өссөн бол импорт 5.2 хувиар агшлаа (Зураг II.5).

Зураг II.5

Гадаад худалдаа бодит дүнгээр алдагдалгүй гарлаа



Эх сурвалж: УСХ

Тайлант улиралд хөл хорио суларч, нүүрсний тээвэрлэлт хэвийн горимд шилжсэн, зэсийн үнэ сэргэсэн, мөн алтны экспорт хоёр дахь улиралдаа дараалан өндөр дүнтэй хийгдсэнээр экспорт эргээд өсөлттэй байна.

Импорт буурахад суудлын автомашин, хөрөнгө оруулалтын зориулалттай тээврийн хэрэгсэл, машин механик, түүний сэлбэг, барилгын материал болон нефтийн бүтээгдэхүүний хэмжээ буурсан нь нөлөөллөө.

Эдийн засгийн салбарууд

Тайлант улиралд “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлснээр нүүрсний экспортыг дэмжсэн, Оюу толгойн зэсийн баяжмал, алтны олборлолт нэмэгдсэн тул уул уурхайн салбарын агшилт саарч -5.2 хувьд хүрснээр эдийн засгийн өсөлтөд -1.1 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв⁶.

Нүүрсний олборлолт өмнөх улирлуудаас нэмэгдсэн хэдий ч төсөөллөөс бага байлаа. Тайлант улиралд нүүрсний олборлолт өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар агшсан нь өмнөх улирлаас 147.6 хувиар өссөн үзүүлэлт юм.


Уул уурхайн бусад эрдэс бүтээгдэхүүний хувьд газрын тос (-2.2%), төмрийн хүдэр (-

⁶ 2020 оны эхний хагаст уул уурхай 29.4 хувиар агшив.

3.6%), Оюу толгойгоос бусад зэсийн баяжмал (-12.8%)-ын олборлолт буурсан бол Оюу толгойн зэсийн баяжмал (+28.3%), алт (+16%)-ны олборлолт нэмэгджээ. Оюу толгойн зэсийн баяжмалын алтны агууламж өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар нэмэгдсэн байна.

Зураг II.6

Уул уурхайн салбарын өсөлт -5.2 хувьд хүрэв.



Эх сурвалж: YCX, Монголбанк

Хэдийгээр нүүрсний тээвэр 8 дугаар сарын дундаас сэргэсэн боловч тайлант улиралд авто замын ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс буурсан тул тээврийн салбарын нэмүү өртөг 14.6 хувиар агшив. Тээврийн салбарын идэвхжил буурсантай холбоотойгоор шатахууны худалдаа саарч, мөн хөрөнгө оруулалтын шинжтэй машин тоног төхөөрөмжийн худалдаа буурснаар худалдааны салбарын өсөлт төсөөллөөс бага буюу -12.5 хувьд хүрсэн.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр томоохон төслийн барилгын ажил удааширч, барилгын салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар агшлаа.

Эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээ нэмэгдсэнээр үйлчилгээний салбарын нэмүү өртөг өмнөх оны мөн үеэс 2 хувиар нэмэгдлээ.

Ургац хураалт, мал төллөлт хэвийн байснаар хөдөө аж ахуйн салбарын өсөлт хүлээлттэй нийцтэй байж, 8.1 хувьд хүрэв.

Эдийн засгийн идэвхжил суларч, авто машины импорт буурснаар бүтээгдэхүүний цэвэр татварын орлого тайлант улиралд 1.8 хувиар буурлаа.


Потенциал үйлдвэрлэл

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт хийгдэж буй бүтээн байгуулалтын

нөлөөгөөр уул уурхайн бус салбар идэвхжсэн нь потенциал үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдэх нөлөөг үзүүлсэн. Харин КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр энэ онд дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, потенциал үйлдвэрлэлийн өсөлт буурахаар байна (Зураг II.7).

Зураг II.7

Потенциал үйлдвэрлэлийн өсөлт




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээлэл, тэдгээрийн хоорондын хамаарлыг ашигладаг олон хувьсагчийн Калман фильтрийн үр дүнгээр потенциал өсөлт буурч 2 хувийн орчимд хүрэхээр байна. Энэ нь үйлдвэрлэлийн функцийн тооцоололтой ойролцоо үр дүн өгч байна. Харин нэг хувьсагчийн НР филтрээр тооцвол потенциал өсөлт энэ онд хурдтай буурах чиглэлд өөрчлөгдөж байна

Үйлдвэрлэлийн зөрүү

Уул уурхайн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн сөрөг зөрүү 2018 онд хаагдаж, 2019 оны турш эерэг түвшинд байв. Гэвч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг энэ оны эхний хагаст хурдтай агшиж, үйлдвэрлэлийн зөрүү эргээд сөрөг болов. Харин 3 дугаар улиралд хорио цээрийн дэглэм алгуур суларсантай холбоотойгоор үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багасч, сэргэх хандлагатай болов. Гэвч энэ оны 11 дүгээр сард тогтоосон бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлаас шалтгаалан эдийн засгийн идэвхжил богино хугацаанд хумигдаж, үйлдвэрлэлийн сөрөг зөрүү эргээд нэмэгдэх эрсдэл бий боллоо. (Зураг II.8).

Зураг II.8

Үйлдвэрлэлийн зөрүү⁷


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Эдийн засгийн цаашдын төлөв

Эдийн засгийн өсөлт энэ оны 3 дугаар улиралд хүлээлтээс доогуур гүйцэтгэлтэй гарлаа. Үүнд, 1) КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөө хүлээлтээс өндөр байснаас гадна төсвийн хөрөнгө оруулалтын зардал дутуу гүйцэтгэлтэй гарч, барилга, боловсруулах, худалдаа, тээврийн салбарын өсөлт төсөөллөөс бага гарав, 2) уул уурхайн салбарын үйлдвэрлэл хүлээлтэд хүрч нэмэгдээгүй нь голлон нөлөөлөв.

Зураг II.9

4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Энэ оны 11 дүгээр сард КОВИД-19-ийн халдвар дотооддоо тархаж, хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор эдийн засгийн өсөлт энэ онд өмнөх төсөөллөөс огцом буурахаар байна. Ирэх онд гадаад эрэлт сэргэх, зэсийн баяжмалын металлын агууламж сайжрах нөлөөгөөр уул уурхайн салбар идэвхжих ч, вирус дотоодод тархсаны улмаас хөл хорионы дэглэм үргэлжилж,

дотоод эрэлт сэргэх хугацаа удааширснаар эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс саарах хүлээлттэй байна (Зураг II.9, Хүснэгт II.1.1).

Уул уурхай: Энэ оны 3 дугаар улирлын гүйцэтгэл хүлээлтээс бага байснаас уул уурхайн салбарын энэ оны өсөлтийн төсөөллийг бууруулав. Ирэх онд гадаад эрэлт сэргэж, нүүрсний үйлдвэрлэл нэмэгдэх, зэс, төмрийн хүдэр зэрэг экспортын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл сайжрах, Оюу толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламж сайжирч, олборлолт нэмэгдэх нь уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэхээр байна.

Уул уурхайн бус: Уул уурхайн бус салбарын үзүүлэлтүүд энэ оны 3-р дугаар улирлаас сайжирч, сэргэх хандлага ажиглагдаж байсан боловч 4-р улиралд КОВИД-19 цар тахал дотоодод тархсантай холбоотойгоор бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн нь ихэнх уул уурхайн бус салбаруудын өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Тухайлбал, боловсруулах, эрчим хүч, барилга, худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварын орлого хатуу хөл хорионоос шалтгаалан огцом буурах төлөвтэй. Харин ургац хураалт сайн байж, мал төллөлт өмнөх оны түвшинд байсан тул хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тогтвортой байхын зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүний экспорт оны сүүлийн улиралд саадгүй үргэлжлэх нөхцөлд тээврийн салбарын үйлдвэрлэл буурахгүй гэсэн тооцоололтой байна. Ирэх онд вирусын тархалт, хөл хорионы дэглэм зэргээс шалтгаалан эдийн засаг сэргэх хугацаа удаашрахаар байгаа тул уул уурхайн бус салбарын өсөлтийг өмнөх төсөөллөөс буурууллаа.

Хүснэгт II.1.1

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл⁸

	2019	2020*	2021*
	гүйц.	төсөөлөл	
ДНБ-ий өсөлт, %	5.1	(-4.2) – (-6.6)	4.5 – 8.3
Уул уурхайн, %	-0.6	(-10.8) – (-13.2)	17.8 – 21.6
Уул уурхайн бус, %	6.7	(-2.4) – (-4.8)	1.3 – 5.1

Эх сурвалж: Монголбанк

⁷ Калман филтрээр тооцсон.⁸ 30 хувийн магадлалтай итгэх интервал

Эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

КОВИД-19 цар тахал дотоодод тархсанаар эдийн засгийн төсөөлөлд нөлөөлж болзошгүй дотоод орчны эрсдэл, тодорхой бус байдал огцом нэмэгдлээ. Вирусын тархалт олон хүнийг хамран, хөл хорио удаан хугацаанд үргэлжлэх нөхцөлд эдийн засаг зогсонги байдалд орж, ажилгүйдэл өсөх, гадаад худалдаа зогсох, төсвийн орлого тасалдаж, алдагдал нэмэгдэх зэргээр эдийн засгийн хүндрэл гүнзгийрэх эрсдэлтэй.

БНХАУ, АНУ, Евро бүс, Орос зэрэг томоохон орнуудын эдийн засгийн өсөлт энэ оны 3 дугаар улиралд хүлээлтээс өндөр гарсан ч вирусын тархалт дэлхий нийтээр дахин эрчимжиж, дараагийн давалгаа үүсэх эрсдэл өндөр байна. Энэ нь дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж, гадаад эрэлт буурах нөхцөлийг бий болгоно.

КОВИД-19 цар тахлын эсрэг зарим вакцины туршилтууд 90-ээс дээш хувийн үр дүнтэй байгаа тухай мэдээ түүхий эдийн зах зээлд оролцогчдод эерэг дохиог өгч, зэс, төмрийн хүдэр зэрэг зарим эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөлөл сайжирлаа. Гэсэн хэдий ч цар тахалтай холбоотой тодорхой бус байдал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд эрдэс бүтээгдэхүүний үнэ эргээд буурах эрсдэл өндөр хэвээр байна.

Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт (2021)

НИЙТ ЭРЭЛТ	Хүлээлт буурсан.
Хэрэглээ	Хүлээлт буурсан.
- Дотоодод КОВИД-19 өвчлөл бүртгэгдсэнээр бүх нийтийн бэлэн байдалд шилжиж, өрхүүдийн хэрэглээ, тэр дундаа хүнсний бус хэрэглээ хумигдах хүлээлттэй байна. - Хүүхдийн мөнгөн тэтгэмж, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн арга хэмжээ 2021 оны эхний хагасыг дуустал хэрэгжих, иргэдийн орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг мөн 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулсан зэрэг арга хэмжээ нь өрхийн хэрэглээний агшилтыг зөөлрүүлэхээр байна. - Цар тахлын үед үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдын нэмэгдэл цалин, урамшуулалтай холбоотойгоор Засгийн газрын хэрэглээний өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна.	
Хөрөнгө оруулалт	Хүлээлт нэмэгдсэн.
- Суурь нөлөөгөөр 2021 оны 2-4 дүгээр улиралд материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, барилга болон машин тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт өндөр өсөлттэй байх - КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хөрөнгө оруулалтын орчинд тодорхой бус байдал үргэлжилж байна. - Бизнесийн зориулалттай зээл олголт өсөлтгүй хэвээр байна.	
Цэвэр экспорт	Хүлээлт буурсан.
- Хөл хорионы арга хэмжээ суларснаар нүүрсний тээвэрлэлт бүрэн хүчин чадлаараа хийгдэж экспортын орлогыг нэмэгдүүлэх, алтны экспортын биет хэмжээ 2020 оны түвшнээс буурах - Уул уурхайн салбар дахь бүтээн байгуулалт, барилгын салбарын хөрөнгө оруулалт сэргэн хөрөнгө оруулалтын шинж чанартай машин тоног төхөөрөмж, барилгын материалын импорт нэмэгдэх	
НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ	Хүлээлт буурсан.
Уул уурхай	Төдийлөн өөрчлөгдөөгүй
2021 оноос нүүрсний экспорт сэргэж, Зэсийн баяжмалын биет хэмжээ, алтны агууламж өсөх нь уул уурхайн салбарын өсөлтөд томоохон эерэг нөлөөтэй байхаар байна.	
Уул уурхайн бус	Хүлээлт буурсан.
2021 оны эхний хагаст уул уурхайн бус салбарууд төдийлөн өсөхөөргүй байгаа бол дараагийн хагас өсөлт сэргэхээр байна. - Цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалж 2021 оны эхний хагаст боловсруулах, барилга, худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний татварын орлого төдийлөн өсөхөөргүй байна. - Нүүрсний экспорт сэргэхээс шалтгаалж авто тээврийн ачаа тээвэр сэргэснээр тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд томоохон эерэг нөлөө үзүүлэхээр байна.	

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт II.1.2

Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт


III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

III.1. Хөдөлмөрийн зах зээл

Тайлант улиралд хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс төдийлөн өөрчлөгдөөгүй (-0.4% буурсан) ч эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч) буурч, эдийн засгийн идэвхгүй хүн ам нэмэгдсэнээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурч 59.6 хувьд хүрлээ.

Зураг III.1.2

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдэж байна⁹



Эх сурвалж: УСХ

Эдийн засгийн идэвхжил буурсан энэ үед ажилгүй хүн амын ажил хайх сонирхол буурч байна. Тухайлбал, ажиллагчдын тоо төдийлөн өөрчлөгдөөгүй байхад ажилгүй иргэдийн тоо буурснаар ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурч, 7.3 хувьд хүрчээ.

Зураг III.1.2

Иргэдийн ажил хайх сонирхол буурч байна.



⁹ Сүүлийн 4 улирлын дундаж өсөлт.

¹⁰ Цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил

Эх сурвалж: УСХ

Хөдөлмөрийн зах зээлийн идэвхжлийг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдийг 4 улирлын дундаж авч үзвэл хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.3 хувьд хүрсэн ч эдийн засгийн идэвхжил өндөр байсан жилүүдээс муу байна.


Ажилгүй хүн ам, боломжит ажиллах хүчин¹⁰, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо буурснаас шалтгаалж хөдөлмөр дутуу ашиглалтын нийлмэл түвшин 12%-д хүрээд байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам бууралттай тул энэ нь ажиллагчид эдийн засгийн идэвхгүй болж байгааг, мөн бүрэн бус хөдөлмөр эрхлэх боломж буурсныг илэрхийлж байна.

Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Өсөлт нь удааширсан дийлэнх салбаруудад ажиллагчдын тоо буурсан байна. Тухайлбал, уул уурхай, боловсруулах, эрчим хүч, барилга, төрөөс бусад үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс багасчээ. Хөдөө аж ахуйн салбар өндөр өсөлттэй байсан ч тус салбарын ажиллагчдын тоо мөн буурчээ. Харин, төрийн үйлчилгээ, мэдээлэл холбоо, тээвэр, худалдааны салбарын ажиллагчдын тоо нэмэгджээ.

Зураг III.1.3

Өсөлт нь удааширсан дийлэнх салбаруудад ажиллагчдын тоо буурч байна.



Эх сурвалж: УСХ

Нийгмийн даатгалд албан журмаар төрийн болон хувийн хэвшлээс даатгуулагчдын

хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн ам

өсөлт эхний 10 сарын байдлаар 1.4 хувиар буурчээ. Харин өмнөх саруудад Ковид-19 цар тахлын улмаас нийгмийн даатгалын шимтгэлээс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл чөлөөлөгдөж байсантай холбоотойгоор буураад байсан сайн дураар даатгуулагчдын тоо 10 дугаар сард 1.2 хувиар нэмэгдлээ.

Зураг III.1.4

Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо буурч байна.



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдэл

Нийгмийн даатгалын сангаас эхний 10 сарын байдлаар 41.5 тэрбум төгрөг (өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өндөр)-ийн тэтгэмжийг 17.9 мянган хүн (өмнөх оны мөн үеэс 1.4 мянгаар цөөн)-д олгоод байна. Мөн цар тахлын улмаас үйл ажиллагаа нь зогссон, борлуулалтын орлого нь 50%-иас дээш буурсан аж ахуйн нэгжийн даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200 мянган төгрөгийн дэмжлэг олгож байна.

Зураг III.1.5

Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс цөөн байна.




Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Давхардсан тоогоор оны эхний 10 сарын хугацаанд 218.1 мянган даатгуулагчдад 43.6 тэрбум төгрөгийн дэмжлэгийг олгожээ.

Эдийн засгийн идэвхжил буурснаар иргэдийн хөдөлмөрийн захын оролцоо буурчээ. Тухайлбал, есдүгээр сарын байдлаар 18.3 мянган ажилгүй иргэн (өмнөх оны мөн үеэс -16.4%) бүртгэлтэй байна. Эхний 9 сарын нийлбэр дүнгээр шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 9.4 мянгаар (16%), ажил идэвхтэй хайгаагүй тул бүртгэлээс хасагдсан иргэд 8.4 мянгаар (17.5%), бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүний тоо өмнөх оны мөн үеэс 2.6 мянга (17%)-аар тус тус буурчээ.

Зураг III.1.6

Иргэдийн хөдөлмөрийн захад оролцох оролцоо буурч байна.



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар


Цалин, өрхийн орлого

Үндэсний статистикийн хорооны тайланаас харахад тайлант улиралд улсын дундаж цалин 1269.1 мянган төгрөг (+8.8%), медиан цалин 942 мянган төгрөг (+11.7%)-т хүрэв. Иргэдийн худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалин буюу инфляцаар зохицуулсан цалин 7 хувиар нэмэгджээ.

Эдийн засгийн дийлэнх салбаруудад цалин өссөн ч идэвхжил багатай салбаруудын цалин төдийлөн нэмэгдээгүй байна. Тухайлбал, эрүүл мэнд, ус хангамж, худалдаа, хөдөө аж ахуй, санхүү даатгал, үйлчилгээний бусад салбаруудад цалин 10%-иас илүү хэмжээгээр өссөн бол боловсруулах (+4.2%), барилга (+2.4%), тээвэр (+3.4%)-ийн салбаруудад цалингийн өсөлт харьцангуй даруухан байв.

Зураг III.1.7

*Хэдийгээр цалин өссөн ч өрхийн орлогын өсөлт
огцом буурлаа.*



Эх сурвалж: YCX


Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл нөхөрлөл (28-30%), хоршооноос гадна төсөвт (15%), ТӨҮГ (15%)-уудад ажиллагчдын дундаж цалин өндөр өссөн бол ХХК-уудад ажиллагчдын цалин хамгийн бага буюу 5.6%-аар нэмэгджээ.

Бүтээмж, нэгж хөдөлмөрийн зардал

Бүтээмжийн өсөлт¹¹-ийн хурд саарсаар байна. Салбаруудаар харвал уул уурхай, барилга, тээвэр, үйлчилгээний салбаруудын бүтээмж буурч, боловсруулах, худалдааны салбаруудын бүтээмжийн өсөлтийн хурд буурч байна. Харин ХАА салбарын бүтээмжийн өсөлт нэмэгдэж байгаа нь тус салбарын үйлдвэрлэлийн өсөлт болон ажиллагчдын тооны бууралтаас давхар шалтгаалж байна.

Зураг III.1.8

*Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт удааширсаар байна.*¹²



Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоолол


III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл

III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

M2 мөнгөний жилийн өсөлт 2020 оны 2 дугаар хагасаас алгуур нэмэгдэж, 10 дугаар сард 10.1 хувьд хүрлээ. M2 мөнгөний өсөлтийг төсвийн алдагдал тэлж, шаардлагатай санхүүжилтийн дүн нэмэгдэж байгаа нь голлон тэтгэж байна. Харин банкны системийн зээлийн үлдэгдэл буурч, гадаад цэвэр активын өсөлт саарч байгаа нь бууруулах нөлөөтэй байв.

Зураг III.2.1.1

М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн,
актив тал



Эх сурвалж: Монголбанк

Энэ оны эхний 10 сарын байдлаар төсвийн шаардлагатай санхүүжилтийн дүн 4.2 их наяд төгрөгт¹³ хүрэв. Уг шаардлагатай санхүүжилтийн 2.3 орчим их наяд төгрөгийг Засгийн газар банкны систем дэх хуримтлалаасаа санхүүжүүлснээр Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) нэмэгдсэн байна (Зураг III.2.1.1).

Харин 2020 оны эхний 10 сард төлбөрийн тэнцлийн алдагдал 294 сая ам.долларт хүрснээр гадаад цэвэр активын өсөлт саарч, M2 мөнгөний өсөлтөд үзүүлэх нөлөө буурч байна.

Түүнчлэн, КОВИД-19 вирусийн тархалттай холбоотойгоор дотоод эдийн засгийн идэвхжил суларч, зах зээл дээрх эрсдэл өндөр байгаа нь зээлийн өсөлт буурахад голчлон нөлөөлж байна.


¹¹ Нэг ажиллагчид ногдох дундаж ДНБ-ий хэмжээ.

¹² Сүүлийн 8 улирлын дундаж өсөлт.

¹³ Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 3 их наяд 259 тэрбум төгрөг, өрийн үндсэн төлбөрт 943 тэрбум төгрөг зарцуулав.

Зураг III.2.1.2

M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний өсөлтийг банкны системийн эх үүсвэр талаас төгрөг болон гадаад валютын хадгаламжийн өсөлт голлон бүрдүүлж байна. Мөн 9 болон 10 дугаар сард банкны системийн төгрөгийн эх үүсвэрийн өсөлт нэмэгдэж байгаа нь эх үүсвэрийн долларжилт буурахад нөлөөлөв. Тодруулбал, банкны системийн эх үүсвэрийн долларжилт 2020 оны 10 дугаар сард 31.4 хувьд хүрч буурлаа.

Зураг III.2.1.3

Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт




Эх сурвалж: Монголбанк

Нөгөө талаас төгрөг болон гадаад валютын харилцах өмнөх оны мөн үеэс буурсан байна.

Зураг III.2.1.4

Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Арилжааны банкуудын нийт зээл болон ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ¹⁴)-ын үлдэгдэл 2020 оны 10 дугаар сарын байдлаар жилийн 3.9 хувиар¹⁵, хэрэглээний зээлийн үлдэгдэл 4.1 хувиар¹⁶ тус тус буурсан байна. Үүнд малчны зээлээс бусад төрлийн хэрэглээний зориулалттай зээлийн үлдэгдэл буурсан нь нөлөөлөв.

Энэ оны 10 дугаар сарын байдлаар бизнесийн зээлийн үлдэгдэл өмнөх оноос 1 хувиар буурлаа. Үүнд аж ахуйн нэгжүүдийн жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн зээлийн үлдэгдэл хумигдсан нь нөлөөлж байна. Тодруулбал, 2020 оны 10 дугаар сарын байдлаар аж ахуйн нэгжүүдийн ЖДҮ-ийн зээлийн үлдэгдэл жилийн 24 хувиар буурчээ. Энэ нь голчлон худалдаа, боловсруулах, барилга, үйлчилгээний салбарт хамаарч байна. ЖДҮ ангилалд ордоггүй бусад ААН-ийн бизнесийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурсан дүнтэй байна. Харин иргэдийн ЖДҮ-ийн зориулалттай зээл жилийн 7.3 хувиар өсчээ.

Энэ оны 1 дүгээр хагаст системийн хэмжээнд ихэнх арилжааны банкууд ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан, нөгөө талаас ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг буурсан байна. Мөн түүнчлэн том болон жижиг банкууд иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан бол дунд банкууд төдийлөн өөрчлөөгүй байна. Харин

¹⁴ Банкууд ипотекийн хөнгөлөлттэй зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпораци (МИК)-д худалдаж, үнэт цаасжуулдаг тул нийт зээлийн өсөлтийг тооцохдоо ИЗББ-г оруулж тооцдог.

¹⁵ Тэтгэврийн зээл тэглэсэн нөлөөг засварлаж тооцвол жилийн өсөлт -0.1 хувь байна.

¹⁶ Тэтгэврийн зээлийг тэглэсэн арга хэмжээний нөлөөг хасч тооцсон.


банкуудын зээлийн нөхцөл төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкууд зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулж эхэлсэн, зээлийн хүүг бага зэрэг бууруулсан, дунд банкууд зээлийн хэмжээг нэмэгдүүлж, барьцаа хөрөнгийн шаардлагыг сулруулан, системийн хэмжээнд зээлийн нөхцөл бага зэрэг сайжирсан байна.¹⁷

Нийт зээлийг валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 30 хувиар тус тус буурав.

Зураг III.2.1.5

Банкны системийн нийт зээл олголт ба зээлийн эргэн төлөлт, тухайн жилийн хуримтлагдсан дүнгээр




Энэ оны эхний 10 сарын байдлаар банкны системээс нийт 16.5 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх жилийн мөн үеэс 4.6 хувиар буурчээ. Энэ нь голчлон бизнесийн зээл олголт буурсантай холбоотой байна. Харин 2020 оны эхний 10 сарын байдлаар зээлийн эргэн төлөлт 17.2 их наяд төгрөг, тэтгэврийн зээл тэглэсэн нөлөөг хасч тооцвол 16.5 их наяд төгрөгт хүрчээ.

Хэрэглээний зээлийн нийт зээлд эзлэх хувь үргэлжлэн буурч, зээлийн үлдэгдлийн бүтэц өөрчлөгдөж байна. Тухайлбал, хэрэглээний зориулалттай зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4 нэгж хувиар буурч 21 хувьд, худалдааны салбарын зээл 1 нэгж хувиар буурч 13 хувьд хүрэв. Харин үл хөдлөх, уул уурхай, бусад үйлчилгээний

салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь нийтдээ 5 орчим нэгж хувиар нэмэгджээ.

Зураг III.2.1.6

Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

Хугацаа хэтэрсэн зээлийн жилийн өсөлт 2020 оны 10 дугаар сард 29.4 хувьд хүрч нэмэгдэв (Зураг III.2.1.6). Нийт хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үеэс 280 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний дийлэнх нь боловсруулах, уул уурхай болон бусад үйлчилгээний салбарын зээлд хамаарч байна. Улмаар хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь 10 дугаар сарын байдлаар 7.2 хувьд хүрч оны эхнээс 2 нэгж хувиар өсөөд байна. Харин чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь оны эхнээс 1.6 нэгж хувиар нэмэгдэж 11.7 хувьд хүрлээ.

Зураг III.2.1.7

Банкуудын хугацаа хэтэрсэн зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

¹⁷ Банкны зээлийн төлөв түүвэр судалгааны тайлан

III.2.2 Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 9 дүгээр сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар, 11 дүгээр сарын ээлжит бус хурлаар дахин 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх, 12-р сарын ээлжит хурлаар 6 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргаад байна.

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2020 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.55 нэгж хувиар буурч 7.67 хувьд хүрэв. Тухайлбал, ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 0.83 нэгж хувиар буурч 7.88 хувьд, банк хоорондын хадгаламжийн хүү 0.75 нэгж хувиар буурч 8.27 хувьд, банк хоорондын захын овернайт зээлийн хүү 0.64 нэгж хувиар буурч 8 хувьд, ТБҮЦ-ны шууд хэлцлийн хүү 0.44 нэгж хувиар буурч 7.51 хувьд хүрсэн байна.

Зураг III.2.2.1

БХЗ-ын хэлцлийн хүү




Эх сурвалж: Монголбанк

Өмнөх онтой харьцуулахад банкуудын шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү шинээр татсан хадгаламжийн хүүнээс хурдтай буурч, зээл болон хадгаламжийн хүүний зөрүү багасав. Тодруулбал, 2020 оны 10 дугаар сард банкуудын шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.98 нэгж хувиар буурч 15.71¹⁸ хувьд хүрсэн бол төгрөгийн хадгаламжийн хүү 0.71 нэгж хувиар буурч 10.42 хувьтай байна. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.27 нэгж хувиар буурч 5.29 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

¹⁸ 2020 оны 10-р сарын байдлаар хөнгөлөлттэй зээлийн хүүг хасч тооцвол зээлийн хүү 16 хувь байна.

Зураг III.2.2.2

Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Харин шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү нэмэгдэж байна. Нэг талаас шинээр олгосон гадаад валютын зээлийн дундаж хүү 2020 оны 10 дугаар сард 10.09 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.19 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Нөгөө талаас шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.81 нэгж хувиар буурснаар гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 2 нэгж хувиар нэмэгдэж 6.71 хувьд хүрчээ.

Хүснэгт III.2.2.1

Шинээр олгосон төгрөгийн зээлийн жинлэсэн дундаж хүү, зээлдэгчдээр (хөнгөлөлттэй зээлийг хассан)

	2019.10 сар	2020.10 сар
Зээлийн хүү, %	16.8	16.0
i. Улсын байгууллага	24.4	4.7
ii. Хувийн байгууллага	16.5	15.8
iii. Санхүүгийн байгууллага	18.3	17.4
iv. Иргэд	17.0	16.4
v. Бусад	14.0	9.7

Эх сурвалж: Монголбанк

II.2.3 Валютын ханш

Он гарснаас хойш алгуур суларч байсан төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 10 дугаар сарын дундаас чангарч, 11 дүгээр сарын эцсийн байдлаар 2849.66 төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь оны эхнээс 115.3 төгрөгөөр буюу 4.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 134.4 төгрөгөөр буюу 5.0 хувиар суларсан үзүүлэлт юм (Зураг III.2.3.1).

Монгол Улс олон улсын зах зээлд бага хүүтэй бондыг амжилттай арилжаалсан, “Саарал жагсаалт”-аас гарсан зэрэг мэдээллүүд хүлээлтэд эерэгээр нөлөөлснөөс гадна энэ оны эхний 8 сард алдагдалтай байсан гадаад валютын урсгал 10 дугаар сард алдалгүй, 11 дүгээр сард 134.4 сая ам.долларын ашигтай гарсан нь төгрөгийн ханшид ирэх дарамтыг зөөлрүүлж байна.

Зураг III.2.3.1

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш




Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) 2020 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар сул тогтлоо. Тодруулбал, төгрөгийн ханш юань, еврогийн эсрэг харгалзан 11.6 хувь, 14.5 хувиар суларсан бол рублийн эсрэг 8.6 хувиар чангарсан байна. /Зураг III.2.3.2/ БНХАУ-ын аж үйлдвэрлэл, эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж, хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэн, Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ тэгийн орчимд хүргэж ам.долларын өгөөж буурсан, Европын холбоо эдийн засгаа сэргээх сан байгуулах нэгдсэн хэлэлцээрт хүрсэн зэргээс шалтгаалан юань, еврогийн ханш ам.долларын эсрэг 7 дугаар сараас хурдтай чангарснаар төгрөгийн ханш ийнхүү тус валютуудын эсрэг сулраад байна.

Зураг III.2.3.2

Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш /оны эхнээс/




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн нэрлэсэн ханш суларч, гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ 1.2 хувиар буурснаар бодит ханш энэ оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар сулрав (Зураг III.2.3.3).

Зураг III.2.3.3

Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Он гарснаас хойш тэгийн орчимд хэлбэлзэж байсан төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн 3 сар дараалан өсч, энэ оны 10 дугаар сард 0.59 хувьд хүрлээ (Зураг III.2.3.4). Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.34 нэгж хувиар өссөн үзүүлэлт болов. Төгрөг болон валютын хадгаламжийн хүүний зөрүү харьцангуй тогтвортой байгаа ч, төгрөгийн ханш ам.долларын эсрэг өмнөх сараас чангарсан нь төгрөгийн өгөөж нэмэгдэхэд голлон нөлөөллөө.

Зураг III.2.3.4

Төгрөгийн харьцангуй өгөөж



III.2.4 Хөрөнгийн зах зээл

Энэ оны 3 дугаар улиралд орон сууцны захын ерөнхий төлөв харьцангуй тогтвортой байсан бол хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд сүүлийн саруудад сэргэх хандлагатай байв.

Орон сууцны зах зээл

ҮСХ-ны тооцоолдог орон сууцны үнийн индекс сүүлийн улирлуудад тогтвортой байна. Тодруулбал, орон сууцны үнийн индекс 2020 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 0.1 хувиар өссөн бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.4 хувиар буурчээ. Харин түрээсийн үнэ өмнөх улирлаас 2.5

Зураг III.2.4.1

Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн өсөлт



хувиар, өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өслөө (Зураг III.2.4.1).

“Тэнхлэг зууч” ХХК-ийн мэдээллээр 2020 оны 3 дугаар улиралд шинэ орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.4 хувиар өссөн бол хуучин орон сууцны үнэ 1.3 хувиар буурсан байна. Энэ нь нийт дүнгээр орон сууцны үнийн

индекс өмнөх улирлаас 0.9 буурахад нөлөөлжээ (Хүснэгт III.2.4.1). Жилийн дүнгээр үзвэл уг индекс өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өсчээ.

Хүснэгт III.2.4.1

Орон сууцны захын үзүүлэлтүүд


		2020-Q2	2020-Q3
Орон сууцны үнийн өсөлт, %			
ҮСХ	улирлаар	0.0	0.1
	жилээр	-1.3	-0.4
Тэнхлэг Зууч	улирлаар	3.8	-0.9
	жилээр	13.3	9.8
Түрээсийн үнийн өсөлт, %	улирлаар	1.8	2.5
	жилээр	5.6	5.7

Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Орон сууцны захын төлөвийг илтгэх үнийн харьцаа үзүүлэлтүүд тайлант улиралд бага зэрэг буурч, үнэ хөөсрөх эрсдэл бага байгааг илтгэж байна. Тухайлбал, ҮСХ ба “Тэнхлэг зууч” ХХК-ий мэдээлдэг орон сууцны үнийн индекс тус бүрээр тооцсон үнэ-түрээсийн харьцаа буурав. Мөн өрхийн дундаж орлого 3 дугаар улиралд нэрлэсэн дүнгээр өмнөх улирлаас 1.9 хувиар өсч орон сууцны үнийн өсөлтөөс давсан нь орон сууцны үнэ-орлогын харьцаа буурахад нөлөөллөө (Зураг III.2.4.2).

Зураг III.2.4.2

Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа



Хөрөнгийн зах зээл


КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр оны эхний хагаст буурсан хөрөнгийн захын ТОП-20 индекс 3 дугаар улиралд эргэж өслөө. Тухайлбал, 2020 оны 10 дугаар сарын дунджаар ТОП-20 индекс 17,458.06 нэгжид хүрсэн нь 2020 оны 6 дугаар сарын

дунджаас¹⁹ 8.3 хувиар өссөн үзүүлэлт болж байна (Зураг III.2.4.3).

Харин хөрөнгийн зах зээлийн үнэлгээний хувьд 6 дугаар сараас эхлэн сэргэх хандлага ажиглагдаж 10 дугаар сард дунджаар 2.56 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь 2-р улирлын дунджаас 4.7 хувиар өссөн дүн юм. Сүүлийн гурван сарын хугацаанд хувьцааны ханшийн өсөлтөөр “Стандарт агрикалчерс групп”, “Тээвэр дархан”, “Талх чихэр” компаниудын хувьцаа тэргүүлж байна²⁰.

Зураг III.2.4.3

Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд



Энэ оны эхний 10 сарын байдлаар хөрөнгийн зах дээр нийт 48.7 тэрбум төгрөгийн арилжаа

хийгдээд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64.3 хувиар буурсан дүн болов. 2020 оны 3 дугаар улиралд арилжааны идэвхийг үнийн дүнгээр “Инвескор ББСБ”, “Ард санхүүгийн нэгдэл”, “АПУ” компаниуд тэргүүлж, арилжааны тоо ширхгээр “Лэндмн ББСБ”, “Мандал даатгал”, “Монос хүнс” компаниуд тэргүүллээ. 10 дугаар сард анхны хөрөнгө оруулалтын сан “Үндэсний хувьчлалын сан”-гийн арилжаа эхэлсэнтэй холбоотойгоор үнэт цаасны арилжааны дүн нэмэгдэж, өмнөх саруудад буураад байсан хөрвөх чадварын харьцаа 3.7 хувьд хүрч нэмэгдлээ (Зураг III.2.4.4).

Зураг III.2.4.4

Хөрвөх чадварын харьцаа



¹⁹ ТОП-20 индекс 2020 оны 6 дугаар сарын дунджаар 16,120.30 нэгжид хүрсэн нь энэ оны хамгийн доод түвшин байв.

²⁰ Эх сурвалж: Market info, www.marketinfo.mn

III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: Төсвийн тодотголоор 2020 онд тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 1.2 их наяд төгрөгөөр (-10.8%) буурахаар байгаа бол нийт зардал 2.9 их наяд төгрөгөөр (+ 25.0%) нэмэгдсэнээр (Хүснэгт III.3.1), төсвийн бодлого өмнөх оноос сулрахаар байна.

Хүснэгт III.3.1

Төсвийн үзүүлэлтүүд

тэрбум төгрөг	2019	2020		2020.10	
	Гүй.	Бат.	Тод.	Гүй.	Гүй %
Нийт орлого	12040	12900	10729	8257	94.7
Ирээдүйн өв сан	1040	977	943	663	100.8
Тогтворжуулалтын сан	95	125	55	37	70.5
Тэнцвэржүүлсэн орлого	10906	11798	9731	7556	94.4
Татварын орлого	9813	10656	8847	6865	95.4
Татварын бус орлого	1092	1142	884	691	85.3
Нийт зардал	11662	13873	14577	10815	83.1
Анхдагч зардал	10801	12913	13605	10012	82.5
Урсгал зардал /-хүүний зардал/	7368	9060	10178	7832	89.8
Хөрөнгийн зардал	3017	3806	3408	2150	63.7
Цэвэр зээл	416	47	19	30	36.0
Хүүний зардал	861	960	973	803	95.7
Нийт тэнцэл	379	-973	-3848	-2558	
ДНБ-д эзлэх хувь	1.0%	-2.4%	-9.9%		
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	-756	-2075	-4847	-3259	
ДНБ-д эзлэх хувь	-2.0%	-5.1%	-12.5%		
Анхдагч тэнцэл	105	-1115	-3874	-2456	
ДНБ-д эзлэх хувь	0.3%	-2.7%	-10.0%		

Эх сурвалж: Сангийн яам

Оны эхний 10 сарын байдлаар төсвийн орлого болон зардал тус бүр төлөвлөгөөнөөс дутуу гүйцэтгэл гарч, төсвийн алдагдал 3.3 их наяд төгрөгт хүрлээ. Оны үлдсэн хугацаанд төсвийн зардал төлөвлөгөөний дагуу зарцуулагдвал төсвийн алдагдал 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байна.


Тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр (14.6 хувь) буурсан бөгөөд орлогын 90.9 хувийг татварын орлого бүрдүүлжээ. 3 дугаар улиралд уул уурхайн салбарт сэргэлт бий болсны зэрэгцээ цар тахал, түүнээс сэргийлэх хорио цээрийн арга хэмжээ зөөлөрснөөр эдийн засгийн идэвхжил нэмэгдэж тэнцвэржүүлсэн орлого өмнөх онуудын улирлын хандлага руу аажим шилжиж эхлээд байв. Бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзвэл:

- Орлогын албан татвар (ОАТ) – 410.4 тэрбум төгрөгөөр ↓
- Нийгмийн даатгалын орлого - 318.4 тэрбум төгрөгөөр ↓
- Бусад татвар – 249.4 тэрбум төгрөгөөр ↓

- Импорттой холбоотой орлого – 190.5 тэрбум төгрөгөөр ↓
- Татварын бус орлого – 141.0 тэрбум төгрөг тус тус буурчээ.

Зураг III.3.1

Төсвийн орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Нийт зардал, цэвэр зээл:


Аравдугаар сарын байдлаар нэгдсэн төсвийн нийт зардал болон цэвэр зээлийн дүн 10'815 тэрбум төгрөгт (83.1 хувийн гүйцэтгэлтэй) хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар (2'516.8 тэрбум төгрөг) өссөн дүн юм. Төсвийн зардлын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс бага байхад урсгал зардал 85.9 хувь (600.0 тэрбум төгрөг дутуу), хөрөнгийн зардал 63.7 хувь (1227.1 тэрбум төгрөг дутуу) гүйцэтгэлтэй байсан нь нөлөөлөв. Зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулан үзвэл:

- Татаас, шилжүүлэг – 1'448.5 тэрбум төгрөгөөр ↑
- Бараа, үйлчилгээний зардал – 610.9 тэрбум төгрөгөөр ↑
- Хөрөнгийн зардал – 587.7 тэрбум төгрөгөөр ↑
- Зээлийн үйлчилгээний төлбөр – 36.0 тэрбум төгрөгөөр ↑
- Эргэж төлөгдөх цэвэр зээл – 137.3 тэрбум төгрөгөөр ↓ өөрчлөгдсөн байна.

Төсвийн хөрөнгийн зардал төлөвлөгөөнөөс 36 хувиар дутуу биелсэн бөгөөд төлөвлөгөөнд хүрэхийн тулд оны үлдсэн хугацаанд 1 их наяд 58 тэрбум төгрөгийн зардал нэмж гаргах шаардлагатай байна.

Зураг III.3.2

Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Энэ онд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь хуульд заасан хязгаар (70%)-т багтаж байна. Өнөөгийн үнэ цэнээр тооцсон Засгийн газрын нийт өрийн хэмжээ ДНБ-ий 54.3 хувьтай тэнцүү байхаар батлагдсан ч тодотголоор энэ харьцаа 62.2 хувьд хүрч өмнөх оноос 3.5 их наяд төгрөгөөр, батлагдсан дүнгээс 2 их наяд орчим төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Хүснэгт III.3.2

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

төрбум төгрөг	2017	2018	2019	2020*	2020*
Гүй.	Гүй.	Гүй.	Бат.	Тод.	
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	20212	18956	20526	22089	24064
ДНБ-д эзлэх хувь (ӨҮЦ-ээр тооцсон)	74.4	58.9	56.1	54.3	62.2
Өрийн хязгаар (ДНБ-д эзлэх хувь)	85.0	80.0	75.0	70.0	70.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	1156	1046	861	960	973
Төсвийн орлогод эзлэх хувь	16.0	11.3	8.0	8.1	10.0
Төсвийн тэнцэл	-1742	12	-628	-2075	-4847
ДНБ-д эзлэх хувь	-6.4	0.0	-1.7	-5.1	-12.5

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

IV.1 Гадаад эдийн засгийн орчны талаарх төсөөлөлд ашигласан таамаглал²¹

Өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад БНХАУ, Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төлөв 2020 онд өмнөх төсөөллөөс сайжрахаар байгаа бол 2021 онд өсөлтийн төсөөллүүд бага зэрэг буурлаа. Харин ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв 2020 онд муудаж, 2021 онд хүлээлтээс сайжрахаар байна.

Гадаад эрэлт²²

БНХАУ-ын дотоод эрэлтийн сэргэлт 3-р улиралд хадгалагдсанаар шинжээчид²³ 2020 оны өсөлтийг 1.8-1.9 хувийн хооронд төсөөлсөн нь дунджаар 1.8 хувь²⁴ буюу өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар нэмэгдэхээр авч үзлээ. Эдийн засгийн гүйцэтгэл 2-р улиралд хүлээлтээс сайн байсан, аж үйлдвэрлэл, нийт хөрөнгө оруулалт идэвхжсэн зэргээс шалтгаалан ОУВС-гийн шинжээчид Хятадын 2020 оны ДНБ-ий өсөлтийн төсөөллийг 1 хувиас 1.9 хувь болгон сайжруулсан. Түүнчлэн, аж үйлдвэрлэлийн салбарын өсөлт нэмэгдсэн, нийт хөрөнгө оруулалт, жижиглэн худалдаа өмнөх төсөөллийн үед агшилттай байсан бол тайлант хугацаанд нэмэгдсэн тул 3-р улирлын эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл хүлээлтээс сайн байв. Аж үйлдвэрлэлийн сэргэлт 10-р сард хадгалагдаж, PMI индекс 51.4 хүрэв. Мөн үйлчилгээний салбарын сэргэлт өмнөх төсөөллийн үед алгуур, жилийн өөрчлөлт нь агшилттай байсан бол тайлант хугацаанд нэмэгдсэнээр аж үйлдвэрлэлийн бус PMI индекс 10-р сард 56.2 хүрч хүлээлтээс давлаа. Дэлхий дахинаа КОВИД-19-ийн тархалтын 2 дахь давалгаа үргэлжилж байгаатай холбоотой тодорхой бус байдал буурах болоогүй тул цаашид төсөв, мөнгөний бодлогоор дотоод эрэлт, өсөлтийг дэмжихээр байна.

²¹Худалдааны түнш орнуудын өсөлт, инфляцын төсөөллийг 2020 оны 11-р сарын 17-ны байдлаарх гадаад орчны төлөв, The EIU-ийн 2020 оны 11-р сарын тайлан, Рубини агентлагийн 11-р сарын тайлан болон Блүмбергийн судлаачдын төсөөллүүдийн медиан утгаас авч, зохих тайлбарыг эдгээр тайлангуудаас нэгтгэн оруулсан. Үүнд Монголбанкны судлаачийн үнэлэлт, дүгнэлт ороогүй болно.

²²Гадаад эрэлтийг Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд эзлэх жингээр худалдааны гол түнш орнуудын

эдийн засгийн өсөлтийг жигнэж тооцов. (Үүнд: БНХАУ 0.90, ОХУ 0.02, Евро бүс 0.08)

²³ EIU, Блүмберг ба Рубини судалгааны байгууллага

²⁴ 2020 оны 11-р сарын 17-ны өдрийн байдлаарх ОУВС, EIU, Блүмберг, Рубини судалгааны байгууллагуудын дундаж төсөөлөл.

Харин 2021 оны төсөөлөл дунджаар 8.1 хувь буюу өмнөхөөс 0.1 нэгж хувиар буурав. Өрхийн хэрэглээний өсөлт цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрэх болоогүй, өмнөх жилийн суурь нөлөө болон хэрэглээг дэмжих Засгийн газраас ирэх 5 жилд хэрэгжүүлэх “dual circulation” өсөлтийн бодлогын нөлөө 2022 оноос илүү мэдрэгдэх хүлээлт зэрэг нь үүнд голлон нөлөөлж байна.

Хүснэгт IV.1.1

Гадаад секторын төсөөллийн таамаглал	
Өмнөх төсөөлөл (2020)	Одоогийн төсөөлөл (2020)
Гадаад эрэлт	Төсөөлөл сайжирсан
Худалдааны "2-р шат"-ны хэлэлцээр шийдвэрлэгдэх хүлээлттэй, БНХАУ-ын өсөлт өмнөх төсөөллийн орчимд, ОХУ, Евро-бүсийн эдийн засгийн өсөлтүүд өмнөх төсөөллөөс буурахаар байна.	БНХАУ, Евро-бүсийн эдийн засгийн өсөлтүүд өмнөх төсөөллөөс сайжрахар бол ОХУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс буурахаар байна.
Худалдааны нөхцөл	Төсөөлөл сайжирсан
БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил өмнөх төсөөллөөс сайжирсан, дэлхийн бусад улс орнуудын өсөлтийн төсөөлөл буурсан ч 5-р сарын дундаас эхлэн вирусны тархалт удааширч, зарим сарын үзүүлэлтүүд эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгааг илэрхийлж байгаа тул түүхий эдүүдийн эрэлтэд эерэгээр нөлөөлж үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдэв.	БНХАУ, Евро-бүсийн эдийн засгийн идэвхжил өмнөх төсөөллөөс сайжирсан, КОВИД-19-ийн эсрэг вакцины туршилтууд амжилттай болсон тул түүхий эдүүдийн эрэлтэд эерэгээр нөлөөлж үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Харин вакцины туршилт амжилттай болсон нь дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулж алтны эрэлт, үнийн төсөөлөл буурав.
Гадаад хүү	Төсөөлөл хэвчлээ
ХНБ 2020 оны 7-р сард хүүгээ 0.0-0.25%-д хэвээр үлдээв. Цаашид 2022 оны төгсгөл хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаар байна.	ХНБ 2020 оны 11-р сард хүүгээ 0.0-0.25%-д хэвээр үлдээв. Цаашид 2022 оны төгсгөл хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаар байна.
Гадаад инфляци	Төсөөлөл буурсан

БНХАУ-аас бусад худалдааны түнш орнуудын өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс буурснаар гадаад эрэлт хүлээлтээс муудсан, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал буураагүй, гахайн мялсан өвчний БНХАУ-ын инфляцид үзүүлэх нөлөө саарч байгаа зэргээс шалтгаалан гадаад инфляцийн төсөөлөл буурчээ.

Худалдааны түнш орнуудын өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс сайжирснаар гадаад эрэлт хүлээлтээс нэмэгдсэн ч, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал буураагүй, эдийн засгийн сэргэлт хэвийн түвшинд хүрээгүй, газрын тосны үнэ төсөөллийн орчимд байхаар байгаа зэргээс шалтгаалан гадаад инфляцийн төсөөлөл буурчээ.

Эх сурвалж: Гадаад эх сурвалжуудаас хийсэн дүгнэлт

ОХУ-ын эдийн засгийг 2020 онд 3.5-4.4 хувийн хооронд, дунджаар 3.6 хувиар агшихаар²⁵ байгаа нь өмнөх төсөөллөөс 1.5 нэгж хувиар сайжирсан үзүүлэлт болов. 3-р улирлын урьдчилсан гүйцэтгэл хүлээлтээс сайн буюу 3.6 хувиар агшсан бөгөөд үүнд өрхийн хэрэглээ, аж үйлдвэрлэл, импортын агшилтын хурд буурсан нь голлон нөлөөлөв. ОХУ-ын эдийн засгийн 2-р улирлын гүйцэтгэл, 3-р улирлын урьдчилсан гүйцэтгэл хүлээлтээс сайн байсан, сүүлийн улиралд цар тахлын тархалтын 2 дахь давалгаа эрчимжсэнээр хөл хорио чангарсан хэдий ч, нийт хөрөнгө

оруулалт, өрхийн хэрэглээ, аж үйлдвэрлэлийн агшилт хүлээлтээс багаар буурсан, Засгийн газрын хөтөлбөрүүдийн нөлөөгөөр барилгын салбар идэвхжсэн, вакцины эхний туршилтууд амжилттай болж, газрын тосны эрэлт хүлээлтээс нэмэгдэх төлөвтэй зэрэг нь 2020 оны өсөлтийн төлөвийг нэмэгдүүлэх шалтгаан болов.

Зураг IV.1.1

Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: Блүмберг, EIU, ОУВС, Рубини, ОУВС

Оросын Төв банк энэ оны 10-р сарын хурлаараа бодлогын хүүг 4.25 хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргасан бөгөөд оны эцэст тус түвшинд хадгалах хүлээлттэй. Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулах хүрээнд батлагдсан багц хөтөлбөр хэрэгжсэнээр, төсвийн алдагдал энэ онд ДНБ-ий 4.4 хувьтай тэнцэхээр байна²⁶. Мөн Үндэсний дэд бүтцийн төслийн хүрээнд 2020-21 онуудад 83 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 7 хувьтай тэнцэх төсвийн багц хөтөлбөрүүд өсөлтийг дэмжих хүлээлттэй байна.

2021 онд ДНБ 2.8-3.9 хувийн хооронд, дунджаар 3.2 хувиар өсөх төсөөлөлтэй буюу өмнөхөөс 0.3 нэгж хувиар нэмэгдэв. Өрхийн хэрэглээ 2020 онд 6.5 хувиар агших бол 2021 онд 4.4 хувиар нэмэгдэж, өсөлтөд дэмжлэг болохоор байна. Одоогоор хэрэгжиж буй татварын зарим хөнгөлөлтүүд (олборлох үйлдвэрлэлийн салбар дахь) 2021 онд цуцлагдсанаар

²⁵ 2020 оны 11-р сарын 17-ны өдрийн байдлаарх ОУВС, EIU, Блүмберг, Рубини судалгааны байгууллагуудын дундаж төсөөлөл.

²⁶ ОХУ-ын ЗГ-аас төсвийн алдагдал ДНБ-ий 4.4 хувьтай тэнцэнэ гэж тооцоолсон бол EIU байгууллагын тооцоогоор төсвийн алдагдал ДНБ-ий 4.3 хувьтай тэнцэнэ гэж үзэж байна.

төсвийн орлого дунджаар 3.8 тэрбум ам.доллараар нэмэгдсэнээр төсвийн алдагдал буурахаар байна. Мөн орлогын албан татварын хувийг хэсэгчилж 13 хувиас 15 хувь хүргэн нэмэгдүүлснээр төсөвт 60 тэрбум рублийг тус тус төвлөрүүлж, төсвийн алдагдал 2021 онд ДНБ-ий 2.2 хувь, 2022 онд 1.2 хувь хүрч тус тус буурах нөхцөл бүрдэхээр байна. Төсөөллийн хугацаанд ОПЕК+ нэгдлийн хүрээнд түүхий нефть, газрын тосны үйлдвэрлэл үргэлжлэн буурах төлөвтэй, барууны орнуудын худалдааны хориг зөөлрөх нөхцөл бүрдээгүй зэрэг нь эрсдэл үүсгэсэн хэвээр байна.

Евро бүсийн эдийн засаг 2020 онд 7.1-8.0 хувийн хооронд, дунджаар 7.6 хувиар агшихаар шинжээчид таамаглаж байна. Энэ нь өмнөхөөс 1.1 нэгж хувиар бууралт багассан үзүүлэлт юм. Европын орнуудад хөл хорио суларч, **өрхийн орлого**, нийт **хөрөнгө оруулалт**, аж үйлдвэрлэлийн салбар дахь **үйлдвэрлэлийн** агшилт буурснаар 3-р улирлын гүйцэтгэл хүлээлтээс сайн байв. Харин оны сүүлийн улиралд цар тахлын хоёр дахь давалгаа Европын орнуудад дэгдэж, Герман, Франц зэрэг улсууд хөл хориог дахин чангатгаад байна. Хэдийгээр КОВИД-19-ийн эрсдэл хэвээр байгаа ч улс орнууд хяналтдаа оруулах хугацаа багассан, вакцины эхний шатны туршилтууд амжилттай үр дүнд хүрсэн, 3-р улирлын гүйцэтгэл хүлээлтээс сайн байсан тул эдийн засгийн сэргэлтийн эрч төсөөллөөс идэвхжих төлөвтэй болж, 2020 оны өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэв. Мөн энэ онд бүсийн аж үйлдвэрлэл, өрхийн хэрэглээ, нийт хөрөнгө оруулалтын агшилт нь буурч, өмнөх төсөөллийн үеэс сайжирсан нь эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэх шалтгаан болов.

2021 оны төсөөлөл 4.8-6.0 хувийн хооронд буюу 5.4 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа нь өмнөхөөс 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлт болов. Европын Төв банкны хасах хүүгийн бодлого, уламжлалт бус мөнгөний бодлого болон бүсийн голлох эдийн засгуудад хэрэгжүүлж буй төсвийн тэлэх бодлого зэрэг нь дотоод эрэлтийг тэтгэх хүлээлттэй хэвээр боловч 2021 онд дэлхийн улс

орнуудад эдийн засгийн сэргэлт жигд бус, гадаад эрэлт өмнөх төсөөллөөс төдийлөн нэмэгдэхээргүй байгаа, вакцинжуулалт бүрэн хийгдэх эсэх нь тодорхой бус, бага өртөгтэй, үр дүнтэй вакцин үйлдвэрлэгдэж нийлүүлэгдэх хурд хүлээлтээс удааширч болзошгүй зэргээс шалтгаалан 2021 оны бүсийн өсөлтийн төсөөллийг бууруулав.

Гадаад худалдааны нөхцөл

Гадаад худалдааны нөхцөл 2020 оны 10-р сард өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар сайжирлаа. Экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар нэмэгдсэн бол импортын үнэ 10.8 хувиар буурчээ.

Экспортын үнэ нэмэгдэхэд зэсийн экспортын хилийн үнэ 35.7 хувиар, төмрийн хүдрийн хилийн үнэ 40.8 хувиар, алтны үнэ 27 хувиар өссөн нь эерэгээр нөлөөлөв. Харин нүүрсний экспортын хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар, газрын тосны хилийн үнэ 34 хувиар, ноолуурын үнэ 11 хувиар буурсан нь сөргөөр нөлөөлөв.


Гадаад инфляц буурч, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ нам түвшинд хадгалагдаж, хэрэглээний бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ хямдарч, улмаар нийт импортын үнэ 10.8 хувиар буурчээ.

Худалдааны нөхцөл 2020 онд өмнөх төсөөллөөс сайжрахар байна (Зураг IV.1.2). Нүүрсний үнийн гүйцэтгэл хүлээлтээс өндөр байсан, зэс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдсэн нь үүнд голлон нөлөөлөв. Зэс, төмрийн хүдрийн нийлүүлэлт бага, вакцины эхний шатны туршилт амжилттай болсон зэрэг мэдээлэл нь үнэд эерэгээр нөлөөлж байгаа бол Хятадын коксжих нүүрсний эрэлт өвлийн улиралд өндөр хадгалагдахаас үүдэн нүүрсний эрэлт, үнэ нэмэгдээд байна. Харин вакцины туршилт амжилттай болсон нь богино хугацаанд зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж алтны эрэлт, үнэ буурав. 2021 онд зэс, төмрийн хүдрийн үнэ өсөх, нүүрс, алтны үнэ экспортын үнэ буурах бол газрын тосны үнэ өмнөх төсөөллийн орчимд байхаар байна. Улмаар

экспортын үнэ буурч, импортын үнэ нэмэгдэх нөлөөгөөр худалдааны нөхцөл 2021 онд өмнөх төсөөллөөс агшилт нь бага зэрэг буурч, ялимгүй сайжрах төлөвтэй.

Зураг IV.1.2

Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Гадаад хүү: АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас цар тахлын нөлөөгөөр тус улсын эдийн засаг 2020 онд 3.7 хувиар агшихаар төсөөлж, 2020 оны 9, 11-р сард бодлогын хүүгээ 0.0-0.25%-д хэвээр хадгалав. Цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлт огцом буурсны дараа хөл хорио, хязгаарлалтуудыг сулруулсны зэрэгцээ төсөв мөнгөний тэлэх бодлогын нөлөөгөөр сэргэж, 3-р улирлын гүйцэтгэл хүлээлтээс сайн байсан хэдий ч хямралаас өмнөх түвшинд хүрэх болоогүй тул 2022-23 он хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаар байна. Мөн “инфляцыг дунджаар 2 хувьд хадгалах” стратегийн хүрээнд Холбооны Нөөцийн Банк санхүүгийн зах зээлийн хөрвөх чадварыг дэмжих, бодит секторт аж ахуйн нэгжүүд болон жижиг дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих хэрэгслүүдийг ашигласан хэвээр байна. Цар тахлын нөлөөг саармагжуулах, өсөлтийг дэмжих хүрээнд 10-р сард батлагдахаар байсан төсвийн багц хойшлов.

Зураг IV.3.5

Холбооны нөөцийн банкны хүү, хувиар



Гадаад инфляцын төлөв өмнөх төсөөллөөс буурав. БНХАУ-ын инфляцыг Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын дунджаар 3.2 хувиас 2.9 хувьд хүргэн бууруулав. Дотоод эрэлт алгуур сэргэж байгаа ч хэвийн түвшинд хүрээгүй, газрын тосны үнэ төсөөллийн орчимд байх зэргээс шалтгаалан инфляцын төсөөлөл буурчээ. Харин цар тахлаас үүдэн хүнсний импортын шаардлагыг чангаруулах нөлөөний улмаас хүнсний үнэ өсөхөөр байгаа бол гахайн мялзан өвчний инфляцад үзүүлэх нөлөө хэвээр байгаа тул үнийг өсгөх хүчин зүйл болж байна. Гахайн мялзан өвчний улмаас гахайн махны нийлүүлэлтийн хомсдол 2022 он хүртэл үргэлжлэх төлөвтэй.

ОХУ-ын инфляц 2020 онд Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын дунджаар 3.3 хувь буюу өмнөх төсөөллийн орчимд байх төлөвтэй байна. Мөнгөний зөөлөн бодлого, дотоод эрэлтийн сэргэлт хадгалагдахаар байгаа нь инфляцыг нэмэгдүүлэх нөлөөтэй ч рублийн сул ханш, геополитикийн асуудлууд нь инфляцад бууруулах хүчин зүйл болсноор инфляц өмнөх төсөөллийн орчимд байх нөхцөлийг бүрдүүлж байна. Дотоод эдийн засгийн гүйцэтгэл хүлээлтээс сайжирсан нөлөөгөөр оны эхний 10 сард инфляц өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өсөв.

АНУ-ын инфляц 2020 онд 0.9 хувь байх төсөөллийг нэмэгдүүлж Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын дунджаар 1.2 хувьд хүргэв. Ажилгүйдлийн түвшин 2020 онд 8.5 хувь хүрч нэмэгдэх, газрын тосны үнэ тайлант хугацаанд хадгалагдсан, дотоод

эрэлтийн сэргэлт үргэлжилсэн, АНУ, БНХАУ хоорондын гадаад харилцаа төсөөллийн хугацаанд сайжрахааргүй байгаа, цар тахлын гурав дахь давалгаа АНУ-д бий болсон нөлөөгөөр тээвэрлэлтийн сүлжээ тасалдах эрсдэлээс үүдэн хүнс, электрон бараа зэрэг бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж болзошгүй зэрэг шалтгаанаар төсөөлөл ийнхүү нэмэгдэв.

Евро бүсийн инфляцыг 2020 онд Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын төсөөллийн дунджаар 0.5 хувиас 0.3 хувьд хүргэн бага зэрэг бууруулав. Цар тахлын нөлөөгөөр бүсийн эдийн засгийн идэвхжил, дотоод эрэлт энгийн түвшинд хүрч нэмэгдэхээргүй байгаа, газрын тосны үнэ төсөөллийн орчимд байх зэрэг нь үүний шалтгаан болов. Мөн хүмүүс хэрэглээгээ нэмэгдүүлэхээс илүү хадгалах хандлага давамгайлж байгаа тул инфляцыг нэмэгдүүлэхээргүй байна.

Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал

Дэлхий дахинд цар тахлын хоёр, гурав дахь давалгаа эрчээ авч буй байдал болон КОВИД-19-ийн вакцинжуулалтын хурд ямар түвшинд байх нь гадаад орчны гол тодорхой бус байдал болж байна. Эрчимжиж буй цар тахлын тархалтаас үүдэх эрсдэл, түүний эсрэг чанга хөл хорио цээрийн арга хэмжээг дахин хэрэгжүүлэх хариу үйлдэл зэрэг нь дэлхийн эдийн засгийн идэвхжлийг хүлээлтээс сааруулж болзошгүй байна. Мөн АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны хязгаарлалтууд хэрхэн үргэлжлэх, хоёр улсын хоорондын таагүй харилцаа даамжрах эрсдэл, АНУ-аас Беларус, ОХУ-д нэмэлт хориг тавих эрсдэл зэрэг геополитикийн тодорхой бус байдлууд хэвээр байна.

IV.2 Түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ

Түүхий эдийн гол нийлүүлэгч орнуудад цар тахлын тархалт нэмэгдэж, нийлүүлэлт буурах хүлээлт, КОВИД-19-ийн эсрэг вакцины туршилтууд амжилттай болсон зэргээс шалтгаалан зэс, төмрийн хүдрийн үнийн төсөөлөл нэмэгдлээ. Харин КОВИД-

19-ийн эсрэг вакцины эхний шатны туршилтууд амжилттай болсон нь тодорхой бус байдлыг бууруулж, алтны үнийн төсөөлөл буурсан бол цар тахлын хоёр дахь давалгааны нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн идэвхжил удааширч болзошгүй тул газрын тосны үнийн төсөөллийг өмнөх төсөөллийн орчимд хадгалав.

Зэс: Нэг тонн зэсийн үнэ 2020 оны 10-р сард дунджаар \$6713 ам.доллар байсан бол 2020 оны 11-р сард дунджаар \$7069 хүрч өсөв. Дэлхийн зэсийн эрэлтийн тал орчмыг дангаараа бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засаг, үйлдвэрлэлийн сэргэлт үргэлжилж, аж үйлдвэрлэлийн салбарын PMI индекс 10-р сард 51.4-д хүрч өссөн, вакцины эхний шатны туршилт 90-ээс дээш хувийн үр дүнд хүрсэн нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ өсөх шалтгаан болов. Мөн зэсийн гол үйлдвэрлэгч Перу, Чили зэрэг улсуудад цар тахлын тархалт төдийлөн буураагүй, хоёр дахь давалгаа бий болох тохиолдолд 2020 онд нийлүүлэлтийн хомсдол үүсч болзошгүй байгаа нь зэсийн үнийг дэмжих нөлөөтэй байна. Зэсийн үнэ Блүүмберг, Рубини, ОУВС, Дэлхийн банк, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын шинжээчдийн төсөөллийн дунджаар 2020 онд \$5980/тонн, 2021 онд \$6653/тоннд хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэх хүлээлттэй. 2021 онд дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх жилийн түвшнээс сэргэн, үнэ нэмэгдэх хандлагатай хэдий ч цаашид АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан даамжрах, КОВИД-19-ийн тархалт үргэлжилж, олон давалгаа үүсч болзошгүй зэрэг нь металлын эрэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй хэвээр байна.

Алт: Нэг унци алтны үнэ 2020 оны 10-р сард дунджаар \$1878 ам.доллар байсан бол 2020 оны 11-р сард \$1866 ам.долларт хүрч буурав. Вакцины туршилт 90-ээс дээш хувийн амжилттай болсноор үнэ ийнхүү буурав. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал бүрэн буураагүй, цар тахлын хоёр дахь давалгаа үргэлжилж буй, худалдааны маргаан даамжрах эрсдэл, төсөв мөнгөний тэлэх бодлогын нөлөөгөөр хөгжингүй орнуудын мөнгөн тэмдэгтийн ханш сулрах эрсдэл

зэрэг нь аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны үнэ огцом унахгүй байхад нөлөөлж байна. Блүүмберг, Рубини, ОУВС, Дэлхийн банк, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын шинжээчдийн төсөөллийн дунджаар алтны үнэ 2020 онд \$1773/унци, 2021 онд \$1809/унци хүрч өмнөх төсөөллөөс буурах хүлээлттэй байна.

Коксжих нүүрс: Австралийн бирж дээр арилжаалагддаг нэг тонн коксжих нүүрсний гэрээний үнэ 2020 оны 10-р сард дунджаар \$105 байсан бол 11-р сард үнэ \$108/тонн хүрч бага зэрэг өсөв. Хятадын дотоодын нүүрс үйлдвэрлэл бага зэрэг буурсан, агуулахууд дахь нөөц буурсан, өвлийн улирлын үйлдвэрүүдийн нөөц бэлтгэлээ базааж буй нь коксжих нүүрсний эрэлтийг нэмэгдүүлж үнэ ийнхүү нэмэгдэв. Дэлхий дахинд цар тахлын хоёр дахь давалгаа үргэлжилж, гадаад эрэлтийн төлөв төдийлөн нэмэгдэхээргүй, худалдааны маргаан даамжрах эрсдэлтэй тул нүүрсний эрэлт, үнэ буурч болзошгүй байна. Коксжих нүүрсний үнэ Блүүмберг, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын төсөөллийн дунджаар 2020 оны дунджаар \$120/тонн, 2021 онд \$126/тонн болж өмнөх төсөөллөөс буурав. 2021 онд Хятадын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс буурах нөлөөгөөр эрэлт буурах, дунд хугацаанд дотоодын коксжих нүүрсний нийлүүлэлт нэмэгдэх хүлээлттэй хэвээр тул үнийг бууруулах хандлагатай байна.

Төмрийн хүдэр: Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 2020 оны 10-р сард дунджаар \$118 байсан бол 11-р сард \$120 хүрч бага зэрэг өсөв. Хятадын Засгийн газраас барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд томоохон хотуудад гангийн үйлдвэрлэлийн идэвхжил хадгалагдаж, төмрийн хүдрийн эрэлт нэмэгдлээ. Мөн Бразил дахь КОВИД-19-ийн тархалттай холбоотойгоор “Vale” уурхай хэвийн хүчин чадлаараа ажиллаж эхлээгүй байгаа нь нийлүүлэлт талаас үнэ нэмэгдэхэд нөлөөлж байна. Төмрийн хүдрийн үнэ Блүүмберг, Рубини, ОУВС, Дэлхийн банк, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын

шинжээчдийн төсөөллийн дунджаар 2020 онд \$98/тонн, 2021 онд \$92/тоннд хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэх хүлээлттэй байна. Төмрийн хүдрийн гол нийлүүлэгч улсуудад цар тахлын хоёр дахь давалгаа үүсч нийлүүлэлтийн хомсдол үүсч болзошгүйн зэрэгцээ эрэлт хадгалагдах төлөвтэй тул 2020-21 онд үнийн төсөөллийг нэмэгдүүлэв.

Түүхий нефть: Нэг баррель Brent маркийн газрын тосны үнэ 2020 оны 10-р сард дунджаар \$42 байсан бол 11-р сард дунджаар \$44 хүрч бага зэрэг өсөв. КОВИД-19-ийн вакцины эхний шатны туршилтууд амжилттай болсны зэрэгцээ ОПЕК+ нэгдэл үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн танаснаар газрын тосны үнэ 11-р сард өсөв. 2020 онд дэлхийн эдийн засгийн идэвхжил сул, олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул газрын тосны үнэ нам түвшинд хадгалагдах хүлээлттэй. Газрын тосны үнэ Блүүмберг, Рубини, ОУВС, Дэлхийн банкны шинжээчдийн төсөөллийн дунджаар 2020 онд \$40/баррель, 2021 онд \$45/баррельд хүрч өмнөх төсөөллийн орчимд байхаар байна.

IV.3 Төлбөрийн тэнцэл


Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны 3 дугаар улиралд 207.0 сая ам.доллар буюу ДНБ²⁷-ий 1.6 хувьтай тэнцэх ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 398.4 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болов. Экспорт сэргэж, импорт агшилттай, орлогын дансны алдагдал буурснаар урсгал тэнцэл 148.7 сая ам.долларын ашигтай байв. Харин ГШХО-ын орох урсгал татарч, бусад хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдсэнээр санхүүгийн тэнцэл 469 сая ам.доллараар багассан нь төлбөрийн тэнцлийг муутгах нөлөөг үзүүлээ. Төлбөрийн тэнцлийн алдаа орхигдуулга өмнөх оны мөн үеэс 258 сая ам.доллараар нэмэгджээ²⁸.

²⁷ 4-н улирлын өссөн нэмэгдсэн ДНБ-ий дүн.

²⁸ Тайлбарлагдахгүй хөрөнгийн дотогшлох урсгалууд нэмэгдсэн.

Зураг IV.3.1

2020 оны 3-р улиралд урсгал дансны ашиг төлбөрийн тэнцлийг ашигтай гарахад нөлөөлөв.




Эх сурвалж: Монголбанк

Урсгал данс сүүлийн 15 улиралд анх удаа ашигтай байв. Тайлант улиралд урсгал тэнцлийн ашиг 148.7 сая ам.доллар (ДНБ-ий 1.1%-)т хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 600 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болов. Экспортын орлого өмнөх оны мөн үеэс 312 сая ам.доллараар нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил сааралттай үед импорт 237 сая ам.доллараар, орлогын дансны алдагдал 110 сая ам.доллараар тус тус агшсанаар урсгал тэнцэл ашигтай гарав. Харин КОВИД 19-ийн нөлөөгөөр аяллын үйлчилгээний орлого татарч, үйлчилгээний дансны алдагдал 50 сая ам.доллараар тэлжээ.

Зураг IV.3.2

Экспорт өсч, импорт, орлогын дансны алдагдал буурснаар урсгал дансны ашигтай гарав.



Эх сурвалж: Монголбанк

Барааны тэнцэл оны 3-р улиралд 714.9 сая ам.долларын ашигтай байв. **Экспорт** 2020 оны 3-р улиралд өмнөх оны мөн үеэс 312 сая ам.доллараар буюу 15.5 хувиар өслөө (Хүснэгт IV.3.2). Тайлант улиралд экспорт

өсөхөд алт, зэсийн экспорт голлох нөлөөтэй байв.

Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ өндөр байсан тул Монголбанк худалдан авсан алт болон өмнөх 2 жилд мөнгөжүүлсэн алтны тодорхой хэсгээс тайлант улиралд 9.3 тонн алт экспортолсон нь нийт экспортод 20.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлээ. Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдаж, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнэ нэмэгдсэн нь зэсийн экспортын орлого нэмэгдэх үндэс боллоо. Төмрийн хүдрийн экспортын тээвэр хэвийн үргэлжилж, экспортын орлого өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өслөө. Энэ оны 8-р сараас “Ногоон гарц” горим хэрэгжиж эхэлснээр нүүрсний экспортын тээвэр өмнөх 2 улиралтай харьцуулахад нэмэгдсэн ч өмнөх оны мөн үеэс бага түвшинд байв.

Хүснэгт IV.3.2

Алт, мөнгө, зэсийн баяжмалын экспорт өсч, нүүрс, газрын тосны экспорт буурав.

	2019 III	2020 III	Жилийн өөрчлөлт	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	2,007	2,319	15.5%	15.5%
Чулуун нүүрс	894	786	-12%	-5.4%
Мөнгөжөөгүй алт	148	560	277%	20.5%
Зэсийн хүдэр, баяжмал	359	425	19%	3.3%
Төмрийн хүдэр, баяжмал	171	180	6%	0.5%
Ноолуур	83	79	-5%	-0.2%
Боловсруулаагүй нефть	92	52	-44%	-2.0%
Цайрын хүдэр, баяжмал	38	44	16%	0.3%
Жонш, лейцит, нефелинт	62	40	-36%	-1.1%
Мөнгө	-	40		2.0%
Мах, махан бүтээгдэхүүн	24	36	51%	0.6%
Машин, тоног төхөөрөмж	32	11	-65%	-1.0%
Бусад	104	66	-37%	-1.9%

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

Импорт 2020 оны 3-р улиралд өмнөх оны мөн үеэс 237 сая ам.доллараар буюу 13.9 хувиар бага байв. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ бага түвшинд хадгалагдаж, нефтийн бүтээгдэхүүний импортын төлбөр буурлаа. Мөн дотоод эрэлт саарч, эдийн засгийн идэвхжил бууралттай байсан тул импортын гол бүрэлдэхүүн хэсгүүд өмнө жилийн мөн үеэс агшив.

Хүснэгт IV.3.3

Дизель түлш, автомашин, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурав.

	2019 III	2020 III	Жилийн өөрчлөлт	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	1,705	1,468	-13.9%	-13.9%


Хэрэглээний бүтээгдэхүүн	426	387	-9.2%	-2.3%
Үүнд: Автомашин	134	93	-30.4%	-2.4%
Хөрөнгө оруулалтын бүт.н	754	732	-2.9%	-1.3%
Нефтийн бүтээгдэхүүн	335	190	-43.3%	-8.5%
Үүнд: Дизель	192	99	-48.2%	-5.4%
Бусад шатахуун	143	90	-36.8%	-3.1%
Аж үйлдвэрлэлийн орц	190	159	-16.5%	-1.8%
Бусад	1	1	3%	0.0%

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал 3-р улиралд өмнөх оны мөн үеэс 50 сая ам.доллараар буюу 17 хувиар өсч -348 сая ам.долларт хүрэв. Үүнд аяллын үйлчилгээний орлого татарсан нь алдагдлыг тэлэх чиглэлд, тээвэр, бусад үйлчилгээний зардал багассан нь алдагдлыг бууруулах чиглэлд нөлөөллөө.

Зураг IV.3.3

Үйлчилгээний алдагдал 3-р улирал өсөв.



Эх сурвалж: Монголбанк


Өмнөх жилүүдэд аяллын үйлчилгээний орлого улирлын онцлогоор 3-р улиралд эерэг орох урсгалтай байсан бол энэ онд КОВИД-19-ийн улмаас дэлхий нийтэд аялал жуулчлал эрс багассан, хил дээрх тодорхой хязгаарлалт зэргээс шалтгаалан аяллын орлого 100 хувь (253 сая ам.доллараар), аяллын зардал 44 хувь (55 сая ам.доллараар) буурав. Гадаад худалдааны эргэлт буурснаар ачаа тээврийн үйлчилгээний алдагдал багасав. Мөн эдийн засгийн идэвхжил суларч, бизнесийн үйлчилгээний зардал багаслаа.

Орлогын дансны алдагдал 2020 оны 3-р улирлын байдлаар 339.7 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 65 сая ам.доллараар буюу 16 хувиар буурав.

Үүнд хөрөнгө оруулалтын орлогын гарах урсгал өмнөх оны мөн үеэс 50.6 сая ам.доллараар буюу 11 хувиар буурсан нь голлон нөлөөлөв. Тодруулбал, банк болон ААН-үүдийн ашигт ажиллагаа буурсны үр дүнд дахин хөрөнгө оруулалтын орлогын гарах урсгал өмнөх оны мөн үеэс 20 сая ам.доллараар буурч 47 сая ам.долларт хүрэв.

Зураг IV.3.4

Орлогын дансны алдагдал буурав.



Эх сурвалж: Монголбанк

Мөн газрын тос экспортлогч компаниудын ногдол ашгийн орлогын гарах урсгал 83 орчим хувиар буурч, 5.5 сая ам.долларт хүрлээ. Тайлант хугацаанд анхдагч орлогын дансны алдагдал урсгал дансны алдагдлын 228 хувьтай тэнцэж байна.


Санхүүгийн дансны тэнцэл 2020 оны 3-р улиралд 110 сая ам.долларын алдагдалтай байсан нь өмнөх оны мөн үеэс 468.6 сая ам.доллараар буюу 131 хувиар буурсан үзүүлэлт болов. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 182 орчим сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалт 26.2 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалт 261.8 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөллөө.

Тайлант хугацаанд Оюу толгой болон бусад ААН-үүдийн ГШХО цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 197.9 сая ам.доллараар буюу 51 хувиар буурч 190.6 сая ам.долларт хүрсэн бол ААН-үүдийн үндсэн төлбөр өмнөх оны мөн үеэс 21 орчим сая ам.доллараар буюу 70 хувиар буурч 8.9 сая ам.долларт хүрэв. Түүнчлэн, тайлант хугацаанд ААН-үүдийн ашигт ажиллагаа бага байснаар орлогын дахин хөрөнгө

оруулалт 24.3 сая ам.доллараар буюу 36 хувиар буурч 42.8 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байв.

Зураг IV.3.5

Санхүүгийн дансны ашиг буурлаа.



Эх сурвалж: Монголбанк

Багцын хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 26.2 сая ам.доллараар буурч, 15.8 сая ам.доллар болсон нь энэ оны 5-р сард төлөгдсөн ХХБ-ны 500 сая ам.долларын бондын аккрузль хүүгийн зөрүүтэй холбоотой байна.


Бусад хөрөнгө оруулалт өмнөх оны 3-р улиралд 176.7 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай байсан бол тайлант улиралд 438.5 сая ам.долларын гарах урсгалтай байв. Дээрх өөрчлөлтөд томоохон ААН экспортын өглөгөө барагдуулсантай холбоотойгоор худалдааны зээл өмнөх оны мөн үеэс 269 сая ам.доллараар нэмэгдэж 222 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай болсон нь голлон нөлөөлөв. Түүнчлэн, өмнөх оны 3-р улиралд 52.9 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан Засгийн газрын урт хугацаат гадаад зээлийн цэвэр урсгал 2020 оны 3-р улиралд өмнөх оны мөн үеэс 73 сая ам.доллараар буюу 138 хувиар буурч 20.2 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай болсон, өмнөх оны 3-р улиралд 52.9 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан бусад секторын гадаад зээлийн цэвэр урсгал өмнөх оны мөн үеэс 78 сая ам.доллараар буюу 239 хувиар буурч 45.4 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай болов.

Гадаад валютын албан нөөц (ГВАН) 2020 оны эхнээс 625.8 сая ам.доллараар буурч

10-р сарын эцэст 3723.0 сая ам.доллар болов²⁹.

Зураг IV.3.6

Гадаад валютын албан нөөц 7.9 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байна.



Эх сурвалж: Монголбанк

Энэ нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 7.9 сарын хэрэгцээг хангах түвшин юм (Зураг IV.3.6).

Төлбөрийн тэнцэл эхний 10 сарын байдлаар 294 сая ам.долларын алдагдалтай байснаар оны эхний хагасын түвшнээс 385 сая ам.доллараар алдагдал буурлаа. Үүнд алтны экспорт нэмэгдэж, нүүрсний экспорт сэргэсэн нь нөлөөлөв. Харин нөгөө талдаа мөнгөжсөн алтны нөөцөөс алт экспортолсон нөлөөгөөр алтны нөөц буурч, ГВАН-ийн өөрчлөлт 10-р сард өмнөх сараас 25 сая ам.доллар байв. Энэ оны эцэст ГВАН 4.0 орчим тэрбум ам.долларт хүрэх, ирэх онд Төлбөрийн тэнцэл 500 гаруй сая ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна.

²⁹ Төлбөрийн тэнцэл болон гадаад валютын нөөцийн зөрүү нь мөнгөжсөн алтны өөрчлөлтөөр тайлбарлагдана.

Хүснэгт IV.3.1

Төлбөрийн тэнцлийн төсөөллийн таамаглал
2020 он

Өмнөх төсөөлөл (2020)	Одоогийн төсөөлөл (2020)
Экспорт	Төсөөлөл сайжирсан.
Худалдан авсан алт+Мөнгөжсөн алтны тодорхой хэсгийг экспортлоно → алтны үнэ ↑ алтны экспорт ↑, Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж буурсан. Нүүрсний экспорт өмнөх хүлээлттэй ижил, Үнийн төсөөлөл ↑: Нүүрсний үнийн гүйцэтгэл, зэс, алт, газрын тос, төмрийн хүдрийн үнийн төсөөлөл ↑.	Худалдан авсан алт+Мөнгөжсөн алтны тодорхой хэсгийг экспортлоно → алтны экспорт өмнөх хүлээлттэй ижил, Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж алгуур нэмэгдэж байна. Нүүрсний гүйцэтгэл ↑ → нүүрсний экспорт ↑, Үнийн төсөөлөл ↑: Зэс, төмрийн хүдрийн үнэ ↑, Нүүрс, газрын тосны үнэ ~, алтны үнэ ↓.
Импорт	Төсөөлөл бага зэрэг нэмэгдсэн.
Оюу толгойн ХО-ын төсөөлөл хэвээр, газрын тос боловсруулах үйлдвэрийн ХО ↓, Төсвийн ХО таналт → ХО-ын бүтээгдэхүүний импорт ↓. Эдийн засгийн идэвхжил ↓ → суудлын автомашины импорт ↓, газрын тосны үнэ ↑ → нефтийн импорт ↑	Оюу толгойн ХО-ын төсөөлөл хэвээр, ХО-ын бүтээгдэхүүний импортын гүйцэтгэл ↑, Хөл хорио (11-12-р сард) → хүнсний импорт ↑, удаан эдэлгээт хэрэглээний импорт ↓, шатахууны импорт ↓. Нүүрсний олборлолт, экспорт ↑ → нефтийн импорт ↑
Үйлчилгээ	Төсөөлөл бага зэрэг сайжирсан.
Ковид-19 → Улсын хил хаасан → аялал жуулчлалын орлого энэ онд орж ирэхгүй гэж үзэв, аялалын зардал мөн багасна. Тэвээр аялалаас бусад үйлчилгээний гүйцэтгэл ↑ → бусад үйлчилгээний төсөөлөл ↑	Ковид-19 → Улсын хил хаасан → аялал жуулчлалын орлого энэ онд орж ирэхгүй, аялалын зардал мөн багасна. Нүүрс, төмрийн хүдрийн экспорт ↑ → тээврийн орлого ↑, Хөл хорио, эдийн засгийн идэвхжил ↓ → бизнесийн үйлчилгээний зардал ↓
ГШХО	Төсөөлөл хэвээр.
Оюу толгойн ГШХО хэвээр. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хүрээнд орж ирэх санхүүжилт энэ онд орж ирэхгүй, хойшлогдох төлөвтэй болсон. Ковид-19-ийн нөлөөгөөр гадаад санхүүжилтууд удааширч, ААН-үүдийн гадаад шууд хөрөнгө оруулалтын төсөөлөл бага зэрэг буурсан.	Оюу толгойн ГШХО хэвээр. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хүрээнд орж ирэх санхүүжилт энэ онд орж ирэхээргүй болсон. Ковид-19-ийн нөлөөгөөр гадаад санхүүжилтууд удааширч, ААН-үүдийн гадаад шууд хөрөнгө оруулалтын төсөөлөл бага зэрэг буурсан.
Бусад ХО	Төсөөлөл муудсан.
ЗГ-ын донор санхүүжилтийн хэмжээ өсч, хувийн секторын урт хугацаат гадаад зээлийн ашиглалтын төлөвлөгөө бага зэрэг нэмэгдсэн. Бэлэн, мөнгө, харилцах дансны гарах урсгал II улиралд нэмэгдсэн.	ЗГ-ын донор санхүүжилтийн хэмжээ өмнөх төсөөллөөс өссөн. Худалдааны зээл дансны гарах урсгал III улиралд нэмэгдсэн.

Эх сурвалж: Монголбанк



МОНГОЛБАНК